
**Тохирлын үнэлгээ - Халал баталгаажуулалтыг гүйцэтгэдэг
байгууллагуудад тавих шаардлага**

MNS OIC/SMIIC 2:2023

ГАРЧИГ

ХУУДАС

ӨМНӨХ ҮГ

ТАНИЛЦУУЛГА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

4. ЗАРЧИМ

4.1 Ерөнхий зүйл

4.2 Исламын шашны мэдрэг асуудал

4.3 Исламын шашны үнэт зүйлсийн үүрэг амлалт

4.4 Эрсдэлд суурилсан хандлага

5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

5.1. Ерөнхий зүйл

5.1.1 Хууль эрх зүйн болон гэрээний асуудал, Исламын шашны үүрэг хариуцлага

5.1.2. Халал баталгаажуулалтын гэрээ

5.1.3 Халал баталгаажуулалтын шийдвэрийн талаарх үүрэг хариуцлага

5.1.4. Лиценз, тохирлын гэрчилгээ болон тохирлын тэмдгийн хэрэглээ

5.2. Шударга байдлын менежмент

5.3. Хариуцлага, санхүүжилт

5.4. Үйл ажиллагаа

5.5. Үл ялгаварлах нөхцөл

5.6 Мөшгөгдөх чанар

5.7 Ил тод байдал

6. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ШААРДЛАГУУД

6.1 Байгууллагын бүтэц, дээд удирдлага

6.2 Шударга байдлыг хамгаалах механизм

6.3 Үйл ажиллагааны хяналт

7. НӨӨЦИЙН ШААРДЛАГУУД

7.1 Удирдлага болон ажилтнуудын чадамж

7.2 Халал баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцдог ажилтнууд

7.2.1 Ерөнхий зүйл

7.2.2 Гэрээний дүн шинжилгээг гүйцэтгэдэг ажилтнууд

7.2.3 Халал баталгаажуулалт олгодог ажилтнууд

7.2.4 Техникийн аудиторууд

7.2.5 Техникийн экспертууд

7.2.6 Исламын шашны экспертууд

7.2.7 Аудитын баг сонгох

7.3 Бие даасан техникийн аудитор, техникийн экспертууд/Исламын шашны экспертуудийг оролцуулах

7.4 Ажилтнуудын бүртгэл

7.5 Аутсорсинг

8. МЭДЭЭЛЛИЙН ШААРДЛАГУУД

8.1 Нийтэд хүртээмжтэй мэдээлэл

8.2 Халал баталгаажуулалтын баримт бичгүүд

- 8.3 Баталгаажсан үйлчлүүлэгчийн лавлах
- 8.4 Халал баталгаажуулалтын лавлагаа, халал тэмдэг/лицензийн ашиглалт
- 8.5 Нууцлал
- 8.6 Халал баталгаажуулалтын байгууллага болон түүний үйлчлүүлэгчид хоорондын мэдээлэл солилцоо
- 9. **ҮЙЛ ЯВЦЫН ШААРДЛАГУУД**
 - 9.1 Ерөнхий шаардлагууд
 - 9.2 Анхдагч аудит ба халал баталгаажуулалт
 - 9.2.1 Өргөдөл гаргах
 - 9.2.2 Өргөдлийг дүн шинжилгээ
 - 9.2.3 Халал анхдагч баталгаажуулалтын аудит
 - 9.2.4 Халал анхдагч баталгаажуулалтын аудит, дүгнэлт
 - 9.2.5 Халал анхдагч баталгаажуулалтын гэрчилгээ олгох мэдээлэл
 - 9.2.6 Дээж авах, түүвэрлэлт
 - 9.2.7 Хяналт ба сорилт шинжилгээ
 - 9.2.8 Аудитын тайлан
 - 9.3 Магадлан хяналтын үйл ажиллагаа
 - 9.4 Давтан баталгаажуулалт
 - 9.5 Тусгай аудит
- 9.6 Халал баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах буюу хамрах хүрээг багасгах
- 9.7 Зарга ба гомдол
- 9.8 Өргөдөл гаргагч болон үйлчлүүлэгчдийн бүртгэл
- 9.9 Баталгаажуулалтад нөлөөлөх өөрчлөлтүүд
- 10. **БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ШААРДЛАГУУД**
 - 10.1. Ерөнхий зүйл
 - 10.2. Менежментийн тогтолцооны гарын авлага
 - 10.3 Баримт бичгийн хяналт
 - 10.4 Бүртгэлийн хяналт
 - 10.5 Удирдлагын дүн шинжилгээ
 - 10.6 Дотоод аудит
 - 10.7 Залруулах ажиллагаа
 - 10.8 Сэргийлэх ажиллагаа
- А ХАВСРАЛТ(норматив) Халал бүтээгдэхүүн/үйлчилгээ/үйл явц мөн/эсхүл менежментийн тогтолцооны ангилал
- В ХАВСРАЛТ (мэдээллийн) Аудит хийх хамгийн бага хугацаа
- С ХАВСРАЛТ (норматив) Халал баталгаажуулалтын байгууллагын ажилд шаардлагатай чадамжийн шалгуур үзүүлэлтүүд
- Ном зүй

ӨМНӨХ ҮГ

Исламын орнуудын Стандарт, Хэмжил зүйн Хүрээлэн (SMIIC) нь Исламын Хамтын Ажиллагааны Байгууллага (OIC)-ын бусэд хэрэгжүүлэх нийтлэг стандартыг тогтоох зорилго бүхий улс орнуудын засгийн газрууд дундын байгууллага юм. Тус Хүрээлэн нь хэрэглэгчдийг хамгаалж, бүтээгдэхүүний харилцан зохицдолгоог хангах, инновац болон чөлөөт худалдааны санаачлагуудыг хөгжүүлэхийн хажуугаар дэлхийн зах зээлд ИХАБ-ын гишүүн орнуудын байр суурийг бэхжүүлэх зорилготой.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц эсхүл менежментийн тогтолцооны Халал баг бүтээгдэхүүний халал байдлыг тогтоох зорилгоор гүйцэтгэдэг тул исламын шашинтай хэрэглэгчдэд хэрэглэж буй бүтээгдэхүүн нь халал болох итгэл үнэмшлийг өгч чаддаг.

Энэ стандартыг ИХАБ-ын Стандартчиллын экспертуудийн бүлэг (СЭБ)-ийн гишүүн дараах орнуудын төлөөлөгчид, ИХАБ болон түүний байгууллагуудын 3 жилийн нэр их хөдөлмөр, 2010 оны зөвшилцлийн үр дүнд боловсруулсан юм:

- a) Афганистан, Албани, Азербайжан, Бангладеш, Арабын Нэгдсэн Эмират, Бруней Даруссалам, Алжир, Индонези, Морокко, Палестин, Габон, Ирак, Иран, Камерун, Катар, Кыргызстан, Кувейт, Ливи, Ливан, Малдив, Малайз, Египет, Нигер, Оман, Узбекистан, Пакистан, Сенегал, Сомали, Судан, Сири, Саудын Араб, Тажикистан, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Йордан, Иемен, Босни Герцоговин,
- b) Исламын Бага Хурлын Байгууллага (ИБХ), ЭЗХХАБХ-ны Зохицуулах алба, Исламын орнуудын Худалдаа, Аж үйлдвэр, Хөдөө аж ахуйн танхим (ИОХАҮХААТ), Исламын орнуудын Статистик, эдийн засаг, нийгмийн судалдаа, сургалтын төв (СЭЗНССТ), Исламын Худалдаа хөгжлийн төв (ИХХТ) болон СЭБ-ын хэрэг эрхлэх газар зэрэг болно.

Анхны хэвлэлийг 2011 оны 5 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Бүгд Найрдамдах Камерун Улсын Яунде хотод зохион байгуулагдсан ИОСХҮХ-ийн Халал хүнсний асуудал хариуцсан Техникийн Зөвлөлийн шуурхай хуралдаанаар хэлэлэлцэн OIC /SMIIC 2:2011-Халал гэрчилгээ олгодог баталгаажуулалтын байгууллагуудад зориулсан арга зүйн зааврыг баталсан.

Энэхүү стандартын хоёрдугаар хэвлэлийг ИОСХҮХ-ийн Тохирлын үнэлгээний Стандартын Хороо (SMIIC/CCA) боловсруулж, ИОСХҮХ-аас OIC/SMIIC 2:2019-Тохирлын үнэлгээ- Халал баталгаажуулалт хэрэгжүүлдэг байгууллагад тавих шаардлагууд нэртэйгээр баталсан.

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод зохион байгуулагдсан ИОСХҮХ-ийн Захирлуудын Зөвлөлийн 11 дэх хуралдаанаар 33-ийн 16/2015 тоот Тогтоолын дагуу 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ИОСХҮХ/TYCХ ньбайгуулагдсан. ИОСХҮХ/TYCХ-ны гол зорилгууд нь сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналт, итгэмжлэл болон холбогдох бусад стандартууд, тэр дундаа халал тохирлын үнэлгээ болон итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцоо

бүхий байгууллагуудын бодлого, стандарт (үүндарга зүйн заавар, шалгуур, техникийн үзүүлэлт гэх мэт багтана)-ыг боловсруулах явдал юм.

Энэхүү стандарт нь Исламын Дүрэм, Хууль зэргээс эхтэй.

Энэхүү стандартын Исламын Дүрэм, Хуулиуд гэдэгт өөр өөр улс орнууд дахь ялгаатай байдлаас үл хамааран нийтээр хүлээн зөвшөөрдөг Исламын дүрэм, дэг жаягийг ойлгоно.

СТАНДАРТЫН ТӨСӨЛ

ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын халал бүтээгдэхүүн, үйл явц эсхүл менежментийн тогтолцоог баталгаажуулалтын ажлын үр дүнд гэрчилгээжүүлэх нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтоолцоо нь холбогдох стандарт болон бусад норм баримт бичгийг мөрдөж байгаа, мөн тухайн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны холбогдох хэсэгт менежментийн тогтолцоог Исламын дүрэмд нийцэх бодлогын хүрээнд хэрэгжүүлдэг болох баталгааг өгч буй нэг арга юм.

Энэхүү стандарт нь халал баталгаажуулалт хэрэгжүүлэгч байгууллагуудад тавих шаардлагуудыг тодорхойлно. Эдгээр шаардлагуудыг дагаж мөрдөх нь халал гэрчилгээ олгогч байгууллагууд нь халал бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц эсхүл менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг чадамжтайгаар, тогтвортой, үнэнч шударга байдлаар үйл ажиллагаа эрхлэхийг хангах зорилготой тул эдгээр байгууллагууд болон тэдгээрийн баталгаажуулалтыг үндэсний, ИХАБ болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх явдлыг дэмжинэ. Энэхүү стандарт нь олон улсын худалдааг хөнгөвчлөх сонирхлын үүднээс халал баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх явдлыг дэмжих суурь болж өгнө.

Энэхүү стандарт нь голчлон ISO/IEC 17065 болон ISO/IEC 17021-1, ISO/TS 22003 норматив эшлэл баримт бичгүүдэд тулгуурладаг бөгөөд халал баталгаажуулалтын байгууллагууд, халал баталгаажуулалтын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын түвшинд гүйцэтгэх дүрэм, гэрчилгээг ашиглах дүрэм, журам, халал баталгаажуулалтын үр дүнд олгосон тэмдэгийн шаардлагыг тодорхойлохыг зорьсон.

Тус стандартын зорилгод, ISO/IEC 17021-1-ийн холбогдох заалтууд болон энд дурьдсан “Менежментийн тогтолцооны стандарт” эсхүл “Шаардлагууд” гэх нэр томъёонууд нь “OIC / SMIIC-ийн халал стандарт эсхүл халал шаардлагууд” ба/буюу “Менежментийн тогтолцооны стандарт” эсхүл “Шаардлагууд” гэдэг утгыг агуулна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Тохирлын үнэлгээ - Халал баталгаажуулалт олгодог байгууллагад тавих шаардлага	MNS OIC/SMIIC 2:2023
Conformity Assessment - Requirements for Bodies Providing Halal Certification	OIC/SMIIC 2:2019

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны ... -р сарын ...-ны өдрийн ... тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн мөрдөнө. болно.

1. ХАМРАХ ХҮРЭЭ

1.1 Энэхүү стандарт нь халал баталгаажуулалтын байгууллагын дагаж мөрдөх дүрмүүд, халал баталгаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлагуудыг тодорхойлно.

1.2 Халал баталгаажуулалтын байгууллагын хэрэглэх халал баталгаажуулалын тогтолцоо нь дараахь үйл ажиллагааны аль нэг эсхүл түүнээс олон үйл ажиллагааг хамарсан байх боломжтой бөгөөд үйл ажиллагаа нь хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоотой (ХАБМТ) нэгэн адил ханган нийлүүлэгчийн менежментийн тогтолцооны үйлдвэрлэлийн хяналт эсхүл үнэлгээ, эсхүл ISO/IEC TR 17026-д тодорхойлсоноор аль алиныг нь хослуулах боломжтой.

- а) загварын туршилт буюу шалгалт;
- б) зах зээлээс буюу ханган нийлүүлэгчийн нөөц эсхүл аль алинаас нь авсан дээжийн шинжилгээ, хяналт;
- с) шинэ буюу хэрэглэгдэж байгаа бүх бүтээгдэхүүн эсхүл тодорхой нэг бүтээгдэхүүний сорилт буюу хяналт;
- д) багц бүтээгдэхүүний сорилт шинжилгээ, хяналт; болон
- е) зохион бүтээлтийн шүүмж дүгнэлт.

Энэхүү стандарт нь халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явцын аудит ба/буюу менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагаагаа чадамжтай, тогтвортой, үнэнч шударгаар хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, шаардлагуудыг тодорхойлно.

Халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц ба/буюу менежментийн тогтолцооны (энэ стандартад “халал баталгаажуулалт” гэж орсон) баталгаажуулалт нь хөндлөнгийн тохирлын үнэлгээний үйл ажилаагаа юм. Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэж буй байгууллагууд нь хөндлөнгийн тохирлын үнэлгээний байгууллага

юм (тус стандартад “халал баталгаажуулалтын байгууллага/ байгууллагууд” гэж орсон).

ТАЙЛБАР 1 Халал баталгаажуулалтын байгууллага нь засгийн газрын бус эсхүл засгийн газрын байгууллага байж болно.

ТАЙЛБАР 2 OIC/SMIIC стандарт ньитгэмжлэл (OIC /SMIIC 3-т нийцүүлнэ) эсхүл ижил төвшний үнэлгээ буюу бусад аудитын үйл явцад шалгур баримт бичиг болгон ашиглах боломжтой.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Доорх эшлэл хийсэн баримт бичгүүд нь энэхүү стандартыг ашиглахад зайлшгүй шаардлагатай. Огноо бүхий баримт бичгийн хувьд зөвхөн эш татсан хэвлэл хэрэглэгдэнэ. Огноогүй баримт бичиг (болон аливаа нэмэлт өөрчлөлт)-ийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл нь хэрэглэгдэнэ.

- ISO/IEC 17021-1, Тохирлын үнэлгээ – Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага,
- ISO/IEC 17065, Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага,
- ISO/IEC 17000, Тохирлын үнэлгээ-Тайлбар толь, ерөнхий зарчим,
- ISO/IEC 17020, Тохирлын үнэлгээ-Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага,
- ISO/IEC 17025, Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадамжид тавих ерөнхий шаардлага,
- ISO 9000, Чанарын менежментийн тогтолцоо-Үндсэн ойлголт ба тайлбар толь,
- ISO/TS 22003, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд аудит болон баталгаажуулалт хийдэг байгууллагад тавих шаардлага.

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тайлбарыг хэрэглэнэ. Энэ хэсэгт байхгүй нэр томъёо, тайлбарыг норматив эшлэл дэх баримт бичиг нэр томъёо, тайлбарыг ашиглана.

3.1

халал баталгаажуулалт

халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц болон/ буюу менежментийн тогтолцоог халал баталгаажуулалтын байгууллагаас баталгаажуулсан гэрчилгээ олгох үйл ажиллагаа

3.2

халал эрх бүхий байгууллага (Исламын эрх бүхий байгууллага)

гишүүн орнуудад зориулагдсан OIC /SMIIC-тэй холбоотой стандартын Исламын үнэт зүйлсийн үндсэн дээр халалтай холбоотой асуудлуудад хяналт тавьдаг байгууллага

3.3

гэрээ (Халал баталгаажуулалтын гэрээ)

халал шаардлагыг даган мөрдөж байгаа нь баталгаажсан өргөдөл гаргагч болон халал баталгаажуулалтын байгууллага/ схем эзэмшигчийн хооронд байгуулсан, халал бүтээгдэхүүн/үйлчилгээ/үйл явц ба/буюу менежментийн тогтолцоонд олгосон логог хэрэглэх эрхийн дүрмийг зохицуулсан хууль зүйн хувьд хэрэгжүүлэх зохицуулалт

3.4

техникийн аудитор

Халал баталгаажуулалтын байгууллагаас албан ёсоор томилогдсон, халал журам болон шаардлагыг боловсруулалтын зохих технологи эсхүл салбарт аудит хийх техникийн чадамжтай хүн

3.5

техникийн шинжээч

Халал баталгаажуулалтын байгууллагаас албан ёсоор томилогдсон, боловсруулалтын зохих технологи эсхүл салбарт техникийн чадамжтай хүн

3.6

Исламын шашны эксперт

Халал болон халал бус асуудлаарх Исламын дүрмийн талаар бүрэн, бүх талын мэдлэгтэй, мэргэжлийн чадамжийг нь холбогдох байгууллага (халал эрх бүхий байгууллага)-аас баталж, баталгаажуулсан, халал баталгаажуулалтын байгууллагаас томилсон исламын шашинтан хүн

3.7

халал бэлэг тэмдэг

Халал баталгаажуулалтын байгууллагаас бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц ба/буюу менежментийн тогтолцооны талаар олгосон Халал гэрчилгээгээр ашиглах эрхийг нь олгосон батлагдсан тэмдэг

3.8

өргөдөл гаргагч

халал баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргагч хувь хүн эсхүл аж ахуйн нэгж

3.9

гэрчилгээ эзэмшигч/баталгаажсан үйлчлүүлэгч/ханган нийлүүлэгч

халал шаардлагын дагуу баталгаажсан халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц ба/буюу менежментийн тогтолцоог ханган нийлүүлэгч хуулийн этгээд

3.10

мөшгөлт

бүтээгдэхүүн (жишээ нь хүнс, тэжээл)-ий хөдөлгөөнийг анхны байдал эсхүл эх үүсвэрээс үйлдвэрлэл, боловсруулалт, савлагаа, хадгалалт эсвэл үзүүлэн,

түгээлт, үйлчлэх зэрэг тодорхой үе шатаар дамжсан эцсийн байдал хүртэл шалгах боломж

3.11

ил тод байдал

баталгаажуулалт, нийгэм, эдийн засаг болон байгаль орчинтой холбоотой шийдвэр, үйл ажиллагааны нээлттэй байдал, мөн эдгээрийг ойлгомжтой, цэгцтэй, цаг хугацаанд нь, шударга, бүрэн гүйцэд байдлаар гүйцэтгэх хүсэл эрмэлзэл. Халал баталгаажуулалтын байгууллагын зохих мэдээллийг бүх хэрэглэгчид болон сонирхогч талуудад нээлттэй байхыг хангах үйл явц, үйл ажиллагаа, арга, мэдээллийн эх үүсвэр, таамгийн үр дүнд ил тод байдал нь илрэн тодорхойлогдоно.

3.12

Исламын ажил хэргийн ёс зүй

IWE

ИАХЁЗ

Мусульман шашны ариун зан үйлийг айлдаж, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх Исламын шашны зарчмуудын багц

ТАЙЛБАР 1 – Исламын ажил хэргийн ёс зүй нь бүх компани, тэдгээрийн ажилтнуудын хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ажилтнууд Исламын ажил хэргийн ёс зүйгээр дамжуулан ариун журамтай байна. SMIIC нь итгэгчдийн ажлын байран дахь оролцоог бүрдүүлж, нөлөөлдөг баримжаа юм. Исламын ажил хэргийн ёс зүй нь бусдыг хүндлэх, ажлын үүрэг хариуцлага, хичээл зүтгэлийг чухалчлах зэрэг зерэг чанарт ач холбогдол өгөх замаар ажлын байран дахь нийгмийн байдалд илүү онцгой анхаардаг. Исламын ажил хэргийн ёс зүй нь аливаа асуудал тулгарахад хамтын ажиллагаа, ярилцах арга барил хамаарна. Ерөнхийдөө, SMIIC нь хүчин чармайлт, ёрсөлдөөн, ил тод байдал, ёс суртахууны хариуцлага гэсэн дөрвөн үндсэн ойлголтоос бүтнэ.

3.13

Ислам аж ахуйн нэгж

Муслим шашинтаны бүрэн эзэмшлийн, мөн тэдгээр хүмүүсийн удирдлагаар үйл ажиллагаа явагддаг хуулийн этгээд.

4. ЗАРЧИМ

4.1 Ерөнхий зүйл

ISO/IEC 17021-1:2015 стандартын 4 дүгээр зүйл болон ISO/IEC 17065:2012 стандартын А хавсралтад тодорхойлсон зарчмууд нь энэхүү стандартын дараагийн онцлог гүйцэтгэл болон тодорхойлсон шаардлагуудын үндэс юм. Эдгээр зарчмуудыг урьдчилан тооцоологүй нөхцлийн үед гаргах шаардлагатай шийдвэрт удирдамж болгон ашиглана. Зарчмууд нь шаардлага биш болно.

4.2 Исламын мэдрэг асуудал

4.2.1 Халал баталгаажуулалтын байгууллага (ХББ) нь Исламын шашин буюу Исламын дүрэмд заасан үндсэн зарчмуудыг баримтлана. “Баримтлах” болон

“Исламын мэдрэг асуудлуудад агуу хүндлэлтэйгээр хандах” гэдэг нь талуудад өөр өөр ач холбогдолтой бөгөөд дагаж мөрдөхийг албаддаг.

4.2.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь өөрийн ажлын байрны орчин, удирдлагын багийн гишүүд, ажилтнууд, ерөнхий байдал, олон нийттэй харилцах харилцаа зэрэгт Исламын үнэт зүйлсийн хамгийн дээд жишгийг баримталбал зохино.

4.3 Исламын үнэт зүйлсийг баримтлах

Халал баталгаажуулалтын байгууллагууд болон түүний ажилтнууд нь Исламын үнэт зүйлс, ялангуяа халалтай холбоотой үнэт зүйлсэд итгэл үнэмшилтэй хандах ёстай.

4.4 Эрсдэлд сууриссан хандлага

Баталгаажуулалтын байгууллагууд нь чадамжтай, тогтвортой, шударгаар баталгаажуулалт хийхтэй холбоотой эрсдэлийг тооцож үзэх хэрэгтэй. Дараах зүйлстэй холбоотой эрсдэлүүдийг хамруулан үзэж болно:

- Халал/Исламын шаардлагууд
- аудитын зорилго
- аудитын үйл явцад ашигласан түүвэрлэлт
- бодит болон ажиглагдсан шударга байдал
- хууль зүйн, зохицуулалтын болон хариуцлагатай холбоотой асуудлууд
- аудит хийлгэж буй үйлчлүүлэгч байгууллага, түүний үйл ажиллагаа эрхэлж буй орчин
- үйлчлүүлэгч болон түүний эрхэлж буй үйл ажиллагааны аудитын нөлөөлөл
- аудитын багийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- сонирхогч талуудын ойлгоц
- баталгаажсан үйлчлүүлэгчийн төөрөгдүүлсэн мэдэгдэл
- тэмдэг ашиглалт

5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

5.1 Ерөнхий зүйл

ISO/IEC 17021-1:2015-ын 5.1 заалт, ISO/IEC 17065:2012-ын 4.1 заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

5.1.1 Хууль зүйн болон гэрээтэй холбоотой асуудлууд, Исламын үүрэг хариуцлага

ISO/IEC 17021-1:2015-ын 5.1.1 дэх заалт, ISO/IEC 17065:2012-ын 4.1.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

Халал баталгаажуулалтын байгууллага нь Ислам аж ахуйн нэгж байх шаардлагатай бөгөөд халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц ба/буюу

менежментийн тогтолцоог Муслим шашинтнуудад зохих ёсоор ханган нийлүүлэх шаардлага хэрэгцээний талаар бүрэн итгэл үнэмшилтэй байх бөгөөд бүхий л үйл ажиллагаандaa Исламын шашны үүрэг хариуцлагыг даган мөрдөхийн тулд шаардлагатай бүхий л алхамыг хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Халал баталгаажуулалтын байгууллага нь Исламын шашны бүхий л шаардлагыг нийцүүлэх үүргийг хүлээнэ.

5.1.2 Халал баталгаажуулалтын хэлэлцээр

ISO/IEC 17021-1:2015-ын 5.1.2 дахь заалт, ISO/IEC 17065:2012-ын 4.1.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

5.1.3 Халал баталгаажуулалтын шийдвэрийн үүрэг хариуцлага

ISO/IEC 17021-1:2015-ын 5.1.3 дахь заалт, ISO/IEC 17065:2012-ын 7.6.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

5.1.4 Лиценз, гэрчилгээ болон тохирлын тэмдэг ашиглалт

ISO/IEC 17065:2012-ын 4.1.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараах хамаарна.

5.1.4.1 Халал баталгаажуулалтын байгууллагын нэр буюу брэнд нэр нь Исламын шашинтай холбоотой аливаа хамааралгүй зүйл эсхүл Исламын шашны үнэт зүйл, дүрэмд харшлах агуулгатай байж болохгүй.

5.1.4.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллага Исламын шашны үнэт зүйл, итгэлд харшлах аливаа лого/тэмдэг/бэлгэдэл, брэнд нэр, сурталчилгаа, уриа ашиглах явдал гаргуулахгүй байх асуудлыг хариуцна.

5.1.4.3 Халал баталгаажуулалтын байгууллага нь Муслим бус аливаа байгууллагад хамраалтай байх, эсхүл тэдгээр байгууллагын лого, тэмдэг, бэлгэдэл, уриаг ашиглах, мөн исламын бус итгэл үнэмшил эсхүл байгууллагыг санагдуулахуйц лого, тэмдэг, бэлгэдэл, уриаг ашиглаж болохгүй.

5.2 Шударга байдлын менежмент

ISO/IEC 17065:2012-ын 4.2 дахь заалт, ISO/IEC 17021-1:2015-ын 5.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараах хамаарна:

5.2.1 Халал баталгаажуулалтын байгууллага болон тухайн хуулийн этгээдийн аль нэг салбар нь халал зөвлөх үйлчилгээ эсхүл менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээ үзүүлж болохгүй.

5.2.2 ISO/IEC 17065:2012-ын 4.2 дахь заалтад дурьдсан “менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээ” нэр томъёог энэхүү стандартын агуулгад нийцүүлэн “халал зөвлөх үйлчилгээ, аюул ослын задлан шинжилгээний зөвлөх үйлчилгээ эсхүл менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээ”-ээр солино.

5.3 Хариуцлага, санхүүжилт

ISO/IEC 17065:2012-ын 4.3 дахь заалт, ISO/IEC 17021-1:2015-ын 5.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

5.4 Үйл ажиллагаа

5.4.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь тодорхой халал бүтээгдэхүүний баталгаажуулалтын тогтолцоон дахь шаардлагад нийцүүлэн холбогдох халал бүтээгдэхүүний стандартуудад нийцэж байг эсэхийг үнэлэхэд шаардлагатай бүхий л алхамыг хийнэ. Халал баталгаажуулалтын байгууллага нь халал баталгаажуулалтын тогтолцооны үндэс болох холбогдох стандартууд эсхүл тэдгээрийн хэсэг, мөн түүвэр дээж авах, сорилт шинжилгээ хийх болон хяналтад тавигдах шаардлага зэрэг аливаа шаардлагуудыг тусгана.

5.4.2 Халал баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхлэхдээ халал баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17025, ISO/IEC 17020, ISO/IEC 17021-1, ISO/IEC 17065, ISO/TS 22003-т тодорхойлсоны дагуу сорилт шинжилгээ, хяналт болон халал баталгаажуулалтыг хийж гүйцэтгэж буй талууд эсхүл хувь хүний чадамжтай байдал болон чадварт тавих шаардлагуудыг зохих байдлаар судлана.

5.5 Үл ялгavarлах нөхцлүүд

ISO/IEC 17065:2012-ын 4.4 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

5.6 Мөшгөгдөх чанар

5.6.1 Мөшгөгдөх чанарыг хангахын тулд аюулгүй ул мөрийн болон мөшгөх тогтолцоог ашиглана. Энэхүү тогтолцоонд бүтээгдэхүүн тус бүрийг тус тусад нь тэмдэглэсэн байна. Уг тэмдэглэгээний механизм нь хуулбарлагдах боломжгүй аюулгүй байдлын онцлог чанартай байна. Тус тогтолцоо нь бүтээгдэхүүн/үйл явц/үйлчилгээ нь ханган нийлүүлэлтийн хэлхээний хоёр үе шатанд хоёуланд нь жинхэнэ бөгөөд Халал болохыг, мөн үйлчлүүлэгчид болон хэрэглэгчид аль аль нь нэвтрэх боломжийг хангасан байвал зохино. Мөн түүнчлэн, уг тогтолцоо нь зах зээлийн хяналтыг илүү нарийвчилсан байдлаар шалгах боломжийг холбогдох төрийн байгууллагад олгох юм.

5.6.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь халал нэгж бүтээгдэхүүний савлагаа болон тээвэрлэлтийн баглаа, боодол бүр тусгай код бүхий өвөрмөц таних тэмдэглэгээ хийхийг заавал шаардана.

5.6.3 Онцгой таних тэмдэглэгээ нь аюулгүй, тамгалсан/наасан, ховхолж авах боломжгүй, арилдаггүй байх бөгөөд багласан хайрцгийг хэсэгчлэн эсхүл бүтнээр нь онгойход хүргэхээргүй, түүнчлэн таних таних тэмдэглэгээний болон үнийн шошгыг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь халхлах ёсгүй.

5.6.4 Импортын бүтээгдэхүүний хувьд, OIC/SMIIC стандартууд болон Халалтай холбоотой норматив бусад баримт бичгүүдэд тусгасан үүрэг хариуцлагыг даган мөрдөөгүй бүтээгдэхүүнд халал тэмдэгийг ашиглах боломжгүй. Хэрэв үйлдвэрлэгч эсвэл экспортлогч эдгээр дүрмийн дагуу тэмдэглэгээний тохиromжтой механизм ашигласан бол эдгээр бүтээгдэхүүнийг импортлоход нэмэлт тэмдэглэгээ хийх шаардлагагүй.

5.6.5 Онцгой таних тэмдэглэгээ нь дараахийг тодорхойлох боломж олгоно:

- a) үйлдвэрлэсэн огноо, газар байршил,
- b) дуусах хугацаа,
- c) харшил үүсгэгчийн мэдээлэл,
- d) орцын мэдээлэл,
- e) бүтээгдэхүүний тодорхойлолт (брэнд гэх мэт),
- f) лабораторийн сорилт шинжилгээний дүн (хэрэв хамааралтай буюу байгаа бол),
- g) гэрчилгээ олгосон эрх бүхий байгууллага, гэрчилгээний дугаар,
- h) импортлогчийн мэдээлэл,
- i) шошгоны хүчин төгөлдөр байдал,
- j) шошгоны серийн дугаар буюу тусгай таних тэмдэглэгээний дугаар.

5.7 Ил тод байдал

5.7.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь өөрийн эрхэлдэг баталгаажуулалтын үйлчилгээнийхээ хүрээнд үйл ажиллагаа нь хамаарах бүх өргөдөл гаргагчид зориулан үйлчилгээгээ хүртээмжтэй байлгана.

5.7.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь үнийн бодлогоо нийтэд хүртээмжтэй байлгана.

5.7.3 Халал баталгаажуулалтын байгууллага нь Халал Итгэмжлэлийн Байгууллагаас шаардсан үед санхүүгийн данс бүртгэлээ үзүүлнэ. Халал баталгаажуулалтын байгууллага нь халал баталгаажуулалттай холбоотой үйл ажиллагаа, түүний дотор орлого, ашиг/алдагдлын тайлан, хувийн болон бусад төрлийн төлбөр болон эдгээр төлбөрүүд хаашаа шилжсэн зэрэг мэдээлэл бүхий орлого зарлагын тайланг хадгална.

6 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШААРДЛАГУУД

6.1 Зохин байгуулалтын бүтэц ба дээд удирдлага

ISO/IEC 17065:2012-ын 5.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

6.2 Шударга байдлыг хамгаалах механизм

ISO/IEC 17065:2012-ын 5.2 дахь заалт, ISO/IEC 17021-1:2015-ын 5.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараахь хамаарна.

6.2.1 Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа явуулдаг улсад хүлээн зөвшөөрөгдсөн Исламын шашны байгууллага нь шударга байдлыг хангах механизмыг хүлээн зөвшөөрсөн байна. Тус байгууллага нь халал баталгаажуулалтын байгууллагын хэрэгжүүлдэг халал баталгаажуулалтын үйл ажиллагааны шударга байдлыг Исламын зарчимд нийцэж байгааг хянах, халал баталгаажуулалтын Исламын асуудалтай холбоотой дүрэм, журам, бодлогыг тодорхойлох үйл ажилаагаанд идэвхтэй үүрэг оролцоотой байна.

6.2.2 Исламын байгууллага нь шударга байдлыг хангахад сөргөөр нөлөөлж болзошгүй Исламын шашны мэдлэг, туршлага, ойлголттой холбоотой зөрүү гарч болзошгүй асуудалд зохих ёсоор анхаарал хандуулж, дүн шинжилгээ хийнэ.

6.3 Үйл ажиллагааны хяналт

ISO/IEC 17021-1:2015-ын 6.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

7. НӨӨЦИЙН ШААРДЛАГУУД

7.1 Удирдлага болон ажилтнуудын чадамж

ISO/IEC 17021-1:2015-ын 7.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагыг мөрдөнө. Түүнчлэн, халал баталгаажуулалтын байгууллага нь ажилтнуудаа өөрийн эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл (А хавсралтыг үзнэ үү)-тэй холбоотой зохих мэдлэгтэй эсэхийг хангах үйл явцтай байх бөгөөд халал баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын үйл явц бүрийн техникийн чиглэл, ажиллагаа тус бүр дээр халал стандарт эсхүл үзүүлэлтийн шаардлагатай холбоотой чадамжийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагатай. В хавсралтын В.1 хүснэгтэд баталгаажуулалтын байгууллага тодорхой ажиллагаануудад тодорхойлсон байх шаардлагатай мэдлэг, ур чадваруудыг тусгасан.

7.2 Халал баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцдог ажилтнууд

7.2.1 Ерөнхий зүйл

7.2.1.1 ISO/IEC 17021-1:2015-ын 7.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараахь хамаарна.

7.2.1.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь аудит болон баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцдог бүх ажилтнууд исламын шашинтай байх ба мэргэжлийн чадамжтай, ёс суртахууны хувьд Исламын ажлын ёс зүйг эрхэмлэдэг байхыг хангах үүрэгтэй.

7.2.1.3 Аудит болон баталгаажуулалтыг үр дүнтэй, нэгдмэл байдлаар явуулах зорилгоор ажилтнуудад чадамжтай холбогдох анхан шатны шалгуур үзүүлэлтийн халал баталгаажуулалтын байгууллага В хавсралтыг харгалzan тодорхойлно. Эдгээр шалгуур үзүүлэлт нь халал баталгаажуулалттай холбоотой OIC/SMIIC-ийн баримт бичгүүд, OIC/SMIIC-ийн халал стандартууд, холбогдох баримт бичгүүд, чанарын менежментийн тогтолцоо, бүтээгдэхүүний

баталгаажуулалт, хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ХАБМТ) болон холбогдох бусад менежментийн тогтолцоог багтаасан байна.

7.2.1.4 Халал баталгаажуулалтын байгууллагын ажилтнууд тухайн байгууллагатай гэрээ байгуулсан эсхүл бусад гадны нөөцөөс ажилладаг бие даасан аудиторууд багтаж болно. Халал баталгаажуулалтын байгууллага нь өөрийн ажилтнууд болон гэрээт ажилтнууд эсхүл гадны байгууллагаас томилогдон ажиллаж буй бүх ажилтнуудаа удирдан зохион байгуулж, хянаж, гүйцэтгэлийг нь хариуцаж, тодорхой салбарт ажиллуулдаг ажилтнуудынхаа чадамжийг хянах энэ талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх шаардлагатай.

7.2.1.5 Халал баталгаажуулалтын байгууллага нь халал баталгаажуулалт хийдэг ажилтнуудаасаа дараах үүргийг хүлээх гэрээ эсхүл бусад баримт бичигт гарын үсэг зурж баталгажуулах шаардлагыг тавина:

- халал баталгаажуулалтын байгууллагын тогтоосон дүрэм, үүний дотор нууцлал, арилжааны болон бусад ашиг сонирхлоос ангид байхтай холбоотой дүрмийг даган мөрдөх,
- томилогдон ажиллах халал аудит эсхүл баталгаажуулалт хийлгэж буй талтай хувиараа эсхүл ажил олгогчоор дамжуулан, эсхүл тухайн бүтээгдэхүүний зохион бүтээгч, үйлдвэрлэгч эсхүл ханган нийлүүлэгчтэй өмнө болон/эсхүл одоо ямар нэгэн холбоотой бол түүнийгээ мэдүүлэх.

7.2.1.6 Халал баталгаажуулалтын үйл явцтай холбоотой ажилладаг ажилтан бүрийн холбогдох мэргэшил, сургалт, туршлагын бүртгэл мэдээллийг халал баталгаажуулалтын байгууллага хөтлөнө.

7.2.2 Гэрээний гүйцэтгэлийн хяналт хариуцсан ажилтан

7.2.2.1 Боловсрол

Халал баталгаажуулалтын байгууллага нь гэрээний хяналт хийдэг ажилтан хамгийн багадаа бүрэн дунд боловсролтой дүйцэх мэдлэгтэй байх нөхцлийг хангах ёстой.

7.2.2.2 Хүнсний аюулгүй байдал ба/бууу халалтай холбоотой сургалт

Халал баталгаажуулалтын байгууллага нь гэрээний хяналт хариуцсан ажилтан дараах сургалтад хамрагдаж амжилттай дүүргэсэн байхыг баталгаажуулна:

- OIC/SMIIC-ийн халал стандартууд болон халал баталгаажуулалттай холбоотой баримт бичгүүд,
- чанарын менежментийн тогтолцоо болон бүтээгдэхүүний баталгаажуулалт,
- холбогдох менежментийн тогтолцооны стандартууд (жишээ нь ISO 22000, ISO 22716).

7.2.2.3 Аудитын сургалт

Халал баталгаажуулалтын байгууллага нь гэрээний гүйцэтгэлийн хяналт хариуцсан ажилтнаа ISO 19011 болон Халал аудитын хүлээн зөвшөөрөгдсөн бусад хөтөлбөрт заасан зөвлөмжид үндэслэн аудитын үйл явцын сургалтад хамрагдсан байхыг батлан хангана.

ТАЙЛБАР Гэрээний гүйцэтгэлийн хяналт хариуцсан ажилтан заавал аудитын туршлагатай байх шаардлагагүй.

7.2.2.4 Чадамж

Халал баталгаажуулалтын байгууллага нь гэрээний гүйцэтгэлийн хяналт хариуцсан ажилтнаа дараах дараах үйл ажиллагааг хянах мэдлэг, ур чадвараа ашиглах чадвартай байхыг хангана:

- а) өргөдөл гаргачдыг хүнсний хэлхээн дэх ангилал болон бусад салбараар ангилах,
- б) өргөдөл гаргагчийн бүтээгдэхүүн болон/эсхүл үйлчилгээ, үйл явц, дадлыг үнэлэх,
- в) халал баталгаажуулалтын аудиторын чадамж, шаардлагыг нэвтрүүлэх,
- с) аудитын хугацаа (Хавсрал Б-г үзнэ үү), үргэлжлэх шаардлагатай хугацааг тодорхойлох,
- д) халал баталгаажуулалтын байгууллагын гэрээний хяналттай холбоотой бодлого, журам.

7.2.3 Халал баталгаажуулалтын гэрчилгээ олгогч албан тушаалтан

7.2.3.1 Ерөнхий зүйл

Халал баталгаажуулалтын байгууллагын баталгаажуулалт олгох шийдвэр гаргагч албан тушаалтан нэг дүгээр ангиллын аудиторын нэгэн адил (А хавсралтыг үзнэ үү) боловсрол, халал баталгаажуулалт болон аудитын сургалтад хамрагдсан, ажлын туршалагатай байх нөхцлийг хангана.

Баталгаажуулалтын шийдвэр гаргагч ажилтан доод тал нь гурван (3) хүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийн нэгээс доошгүй нь халал баталгаажуулалтын байгууллагын ажилтан, нэгээс доошгүй нь Исламын шашны эксперт байна. Шийдвэрийг санал нэгтэйгээр, олонхийн бус саналаар гаргана.

7.2.3.2 Чадамж

Халал баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалт хариуцсан баг дараах асуудлаарх мэдлэг, ур чадвараа ашиглах чадвартайг батална:

- а) ИОСХЗХ-ийн халал баталгаажуулалтын одоогийн зарчмууд,
- б) халал баталгаажуулалттай холбоотой Исламын дүрэм,
- с) холбогдох менежментийн тогтолцооны өнөөгийн зарчим, ойлголт,
- д) халал шаардлагын эрсдэлийн тодорхойлолт, үнэлгээ,
- е) халал асуудалтай холбоотойгоор авах залруулга, залруулах арга хэмжээ,
- ф) халал бүтээгдэхүүн/үйлчилгээ/үйл явцтай холбоотой аливаа хууль, зохицуулалт,
- г) бүтээгдэхүүн, үйл явц, дадал,
- х) аудитын тайлангийн үнэн зөв, бүрэн байдлын үнэлгээ, хяналт,
- и) залруулах арга хэмжээний үр ашгийн үнэлгээ, хяналт,
- ж) баталгаажуулалтын үйл явц,
- к) халал хүнстэй холбоотой үндсэн дүрэм, нөхцөл, нэн ялангуяа амьтаниг Исламын дүрмийн дагуу нядлах, OIC/SMIIC-ийн стандарт, зөвлөмжүүд болон бусад холбогдох стандартын шаардлагуудын талаарх сайн ойлголттой.

7.2.4 Техникийн аудиторууд

7.2.4.1 Ерөнхий зүйл

Халал баталгаажуулалтын техникийн аудиторууд халал баталгаажуулалттай холбоотой Исламын дүрмийн холбогдох мэдлэгтэй, OIC/SMIIC-ийн халал баталгаажуулалтын баримт бичгийн сургалтанд хамрагдсан, үзүүлэлт болон техникийн баримт бичгийг судалсан байдаг.

7.2.4.2 Боловсрол

Халал баталгаажуулалтын байгууллага техникийн аудиторуудаа дээд эсвэл дунд боловсролын дараах шаардлагатай боловсролтой, мэдлэгтэй, түүний дотор холбогдох аж үйлдвэрийн салбарын халал баталгаажуулалтын аудит гүйцэтгэх сургалтанд хамрагдсан (А хавсралтын Хүснэгт А.1-ийг үзнэ үү)-аар байхыг батлан хангана.

7.2.4.3 Тусгай сургалтууд

7.2.4.3.1 Техникийн аудиторууд дараах сургалтад амжилттай хамрагдсан байхыг халал баталгаажуулалтын байгууллага хангана:

- а) менежментийн холбогдох зарчмууд,
- б) холбогдох салбарын журмууд,
- с) OIC/SMIIC-ийн халал стандарт, зөвлөмжүүд,
- д) салбарын тусгай сургалт.

7.2.4.3.2 Халалтай холбоотой сургалтуудыг тохирсон, хэрэгцээ шаардлагатай болохыг халал асуудал хариуцсан эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай. Сургалтыг холбогдох чиглэлээр мэргэшсэн бие даасан этгээд баталж, гэрчилгээ олгодог бол тухайн сургалт OIC/SMIIC-ийн халал баталгаажуулалтад заасан шалгуурыг хангаж байгаа тодорхой баталгаа болж өгнө.

7.2.4.4 Аудитын сургалт

Техникийн аудиторууд ISO 19011 эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бусад сургалт эсхүл ажилтны баталгаажуулалтын тогтолцоонд үндэслэсэн аудитын техникийн сургалтад хамрагдсан байхыг халал баталгаажуулалтын байгууллага хангана.

Түүнээс гадна дараах сургалтад амжилттай хамрагдсан байна:

- а) холбогдох менежментийн эсхүл үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартууд (жишээ нь ISO 22000, ISO 22716),
- б) OIC/SMIIC-ийн халал стандартад үндэслэсэн халал баталгаажуулалтын сургалт.

7.2.4.5 Ажлын туршлага

Техникийн аудитор доод тал нь 4 жилийн ажлын туршлагатай байх бөгөөд үүнээс багадаа 2 жил нь халал баталгаажуулалт эсхүл халал тохирлын үнэлгээний чиглэлээр ажилласан байна.

7.2.4.6 Аудитын туршлага

Техникийн аудитор нь сүүлийн гурван (3) жилд доод тал нь гурван (3) байгууллагад хөндлөнгийн аудитороор, эсхүл хөндлөнгийн/хоёрдогч талын аудиторын үүргийг гүйцэтгэгч мэргэшсэн аудиторын удирдлага дор баталгаажуулалтын доод тал нь аудитын арван (10) өдөр (ХАБМТ-той ижил эсхүл бүтээгдэхүүн/үйлчилгээ/үйл явцын баталгаажуулалтын тогтолцоо) гүйцэтгэсэн эсэх туршлагыг халал баталгаажуулалтын байгууллага нэн тэргүүнд харна.

ТАЙЛБАР – ХАБМТ аудитын өдөрт хүнсний үйлдвэрлэл дэх ISO 90001 эсхүл ХАБМТ-ын бусад аудит (ХАБТБ шиг)-ыг багтаана.

7.2.4.7 Чадамж

7.2.4.7.1 Техникийн аудиторын ур чадварыг ангилал, салбар тус бүрээр бүртгэнэ (А хавсралтыг үзнэ үү). Халал баталгаажуулалтын байгууллага нь үнэлгээ амжилттай хийгдсэн нотлогоог гаргаж өгнө.

7.2.4.7.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь техникийн аудиторууд дараах чиглэлийн мэдлэг, ур чадвараа ашиглахыг нотлон хангана:

а) Аудитын зарчим, журам, техникууд: аудитор доор дурьдсан зохих ажиллагааг өөр өөр аудитад ашиглах боломжийг олгохын сацуу аудитыг тууштай, дэс дараатай аргаар гүйцэтгэх явдлыг хангана. Аудитор нь:

- аудитын зарчим, журам, аргуудыг ашиглах,
- ажлаа үр ашигтайгаар төлөвлөн, зохион байгуулах,
- аудитыг тохирсон хугацаандаа хийж гүйцэтгэх,
- чухал асуудлуудлыг эрэмбэлж, тэдгээрт анхаарлаа хандуулах,
- үр дүнтэйгээр ярилцлага хийх, сонсох, ажиглах, баримт бичиг хянах замаар мэдээлэл цуглуулах,
- бүртгэл, мэдээлэл
- аудитад дээжийн техник ашиглах зохимжит байдал, үр дүнг ойлгох,
- цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах,
- аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүгнэлтийг дагалдах аудитын нотлох баримт хангалттай, зохистой байдлыг баталгаажуулах,
- аудитын илрүүлэлт, дүгнэлтийн найдвартай байдалд нөлөөлөхүйц хүчин зүйлсийг үнэлэх,
- аудитын үйл ажиллагааг бүртгэл ажлын баримт бичгийг ашиглах,
- аудитын тайлан бэлтгэх,
- мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах,
- өөрийн хэлний чадвар эсхүл орчуулагчаар дамжуулан үр дүнтэйгээр харилцах чадварыг тус тус эзэмшсэн байна.

б) Бүтээгдэхүүн/үйлчилгээ/үйл явцын баталгаажуулалт мөн/эсхүл менежментийн тогтолцоо болон бусад лавлах баримт бичгүүд буюу OIC/SMIIC-ийн Халал сатандартууд болон OIC/SMIIC-ийн бусад стандартууд: аудитор аудитын хамрах хүрээ, аудитын шалгуурыг ашиглах явдлыг хангана.

- c) Байгууллагын нөхцөл байдлууд: техникийн аудиторыг тухайн байгууллагын үйл ажиллагааны нөхцөл байдлын талаар ойлголттой болох явдлыг хангана.
- d) Холбогдох хууль, журам, тус чиглэлтэй холбоотой бусад хууль эрх зүй, халал шаардлагууд: техникийн аудиторууд аудит гүйцэтгүүлж буй байгууллагын дотор ажиллаж, тухайн байгууллагад хамаарах шаардлагын талаар мэдлэг ойлголттой болох явдлыг хангана.

7.2.4.7.3 Халал баталгаажуулалтын байгууллага нь техникийн аудиторуудаа аль нэг салбарын болон доорх хэсгийн нэр томъёо, мэдлэг, ур чадварыг ашиглахыг хангана:

- a) тодорхой салбар(үүд)-ын бүтээгдэхүүн, үйл явц, туршлага (А хавсралтыг үзнэ үү),
- b) хамааралтай тохиолдолд холбогдох менежментийн тогтолцооны шаардлагууд,
- c) холбогдох бүтээгдэхүүн/үйлчилгээний стандартууд,
- d) холбогдох халал шаардлагууд.

7.2.5 Техникийн экспертууд

7.2.5.1 Боловсрол

7.2.4.2 дахь заалтад тодорхойлсон шаардлагууд хамаарна.

7.2.5.2 Ажлын туршлага

Халал баталгаажуулалтын байгууллага нь техникийн экспертуудийг өөрийн техникийн чиглэлээр доод тал нь дөрвөн (4) жилийн ажлын туршлагатай байна.

7.2.5.3 Чадамж

Халал баталгаажуулалтын байгууллага нь техникийн экспертууд өөрийн техникийн чиглэлээр мэдлэг, ур чадвараар хангана.

7.2.6 Исламын шашны экспертууд

7.2.6.1 Боловсрол

Халал баталгаажуулалтын байгууллага нь Исламын шашны экспертууд нь Исламын дүрмийн доод тал нь ахлах сургуулийн боловсролтой дүйцэхүйц мэдлэгтэй байхыг хангана. Экспертуудийг Халал эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрсөн байна.

7.2.6.2 Ажлын туршлага

Халал баталгаажуулалтын байгууллага нь Исламын шашны экспертуудийг Ислам ажил хэрэгтэй холбоотой салбарт доод тал нь хоёр (2) жилийн ажлын туршлагатай байна.

7.2.6.3 Чадамж

Исламын шашны экспертууд халал баталгаажуулалттай холбоотой Исламын дүрмийн талаарх мэдлэг, ур чадвараа батлан харуулах явдлыг Халал баталгаажуулалтын байгууллага хангана.

7.2.7 Аудитын баг сонгох

7.2.7.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь халал баталгаажуулалтын аудитын багийг сонгохдоо тухайн салбарт аudit хийхэд шаардлагатай чадамжтай байх явдлыг хангана (А хавсралтыг үзнэ үү).

7.2.7.2 Аудитын баг доод тал нь хоёр (2) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг нь тэргүүлэх аудиторын мэргэшил, чадамж эсхүл баталгаажуулалт бүхий техникийн аудитор байх бол нөгөө нь Исламын шашны эксперт байна.

7.3 Бие даасан, хөндлөнгийн техникийн аудитор, хөндлөнгийн техникийн эксперт/Исламын шашны экспертийг ажиллуулах

ISO/IEC 17021-1:2015-ын 7.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна. Үүнээс гадна Исламын шашны экспертэд бие даасан техникийн экспертэд тавих бүх шаардлагууд хамаарна.

7.4 Ажилтнуудын бүртгэл

ISO/IEC 17065:2012-ын 6.1.2.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

7.5 Аутсорсинг

ISO/IEC 17021-1:2015-ын 7.5 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараах хамаарна.

7.5.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь халал баталгаажуулалттай холбоотой ажил үүрэг (аудит, сорилт шинжилгээ, хяналт гэх мэт)-ийг хөндлөнгийг байгууллага эсхүл хүнийг аутсорсинг хийхээр шийдсэн бол нууцлал болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зохицуулалтыг тусгасан, сайтар баримтжуулсан гэрээг боловсруулна.

7.5.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь:

- аутсорснинг хийсэн ажил үүргийн хариуцлагыг бүрэн хүлээж, халал баталгаажуулалт олгох, хадгалах, сунгах, түдгэлзүүлэх буюу цуцлах үүрэг хариуцлагаа хэвээр хадгална,
- Аутсорс хийсэн байгууллага эсхүл хүн шаардагдах мэдлэг туршлагатай, энэхүү стандартын холбогдох заалтууд, сорилт шинжилгээ, хяналт, техникийн бусад үйл ажиллагаатай холбоотой холбогдох бусад баримт бичгийг дагаж мөрдөх, халал бүтээгдэхүүн/үйлчилгээний загвар эсхүл үйлдвэрлэлд шудрага байдлыг алдагдуулах хэмжээнд шууд эсхүл ажил олгогчоороо дамжуулан оролцуулахгүй байх,
- хүсэлт гаргагчийн аутсорсинг хийх зөвшөөрлийг авах,
- аутсорсингийн баталгаажсан үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлэл, гэрээлсэн ажлын хамрах хүрээ, тэдний чадамжийг нотлох холбогдох бүртгэл зэргийг багтаасан жагсаалтыг гаргасан байна.

8 МЭДЭЭЛЛИЙН ШААРДЛАГУУД

Баталгаажуулалтын баримт бичигт баталгаажуулалтанд хамрагдсан үйл явц, үйлчилгээ эсхүл бүтээгдэхүүнийг салбар бүрээр дурьдан, дэлгэрэнгүй тодорхойлсон байна.

8.1 Нийтэд хүртээмжтэй мэдээлэл

ISO/IEC 17065:2012-ын 4.6 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

8.2 Халал баталгаажуулалтын гэрчилгээний баримт бичгүүд

ISO/IEC 17065:2012-ын 7.7 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

8.3 Баталгаажсан үйлчлүүлэгчийн лавлах

ISO/IEC 17065:2012-ын 7.8 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараах хамаарна.

- а) баталгаажуулалтын хамрах хүрээ,
- б) үйлчлүүлэгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний байршил (газар зүйн байршил (хот, улс гэх мэт)).

Тайлбар – Тус лавлах нь халал баталгаажуулалтын байгууллагын өмч байна.

8.4 Халал баталгаажуулалтын лавлагаа, халал тэмдэг/лицензийн ашиглалт

ISO/IEC 17021-1:2015-ын 8.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон дараах хамаарна.

8.4.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь лиценз, халал гэрчилгээ, халал тохирлын тэмдгийн эзэмшил, хэрэглээ, нийтлэн сурталчлах байдалд зохих хяналтыг хэрэгжүүлнэ.

8.4.2 Халал баталгаажуулалтын байгууллагын олгосон халал гэрчилгээ, халал тэмдгийн хэрэглээний талаарх зөвлөмжийг холбогдох ИОСХҮХ-ийн баримт бичгээс авах боломжтой.

8.4.3 Зар сурталчилгаа, каталог зэрэгт байршуулсан халал баталгаажуулалтын тогтолцоо, лиценз, халал гэрчилгээ, тэмдгийн талаарх ташаа мэдээлэлд зохих арга хэмжээг авч шийдвэрлэнэ.

8.4.4 Халал гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээгээ шинэчлээгүй тохиолдолд халал тэмдгийг өөрийн байр эсхүл үйлдвэрлэсэн халал бүтээгдэхүүн/үйлчилгээ, хүнсний дэлгүүр дотор эсхүл их дэлгүүрийн танхимд ашиглахыг хориглоно.

8.4.5 Халал тэмдэг нь ИОСХҮХ-ийн баталсан шаардлагатай үзүүлэлтэд нийцэх ёстой.

8.4.6 Халал тэмдгийг баталгаажсан бүх халал бүтээгдэхүүн дээр тод байдлаар хэвлэж, бүтээгдэхүүний хайрцаг/савалгаан дээр шошгожуулан байрлуулсан байна.

8.4.7 Компаниуд халал тэмдгийн анхдагч үзүүлэлтийг өөрчлөөгүй тохиолдолд тус тэмдгийн өнгийг сав, баглаа, боодолдоо тохируулан хэвлэхийг зөвшөөрнө.

8.4.8 Баталгаажсан халал үйлчилгээний халал тэмдэг/гэрчилгээг баталгаажуулалт хийлгэсэн байгууллага зөвхөн орох хэсэгт байршуулж тавих боломжтой.

8.4.9 Гэрчилгээ эзэмшигч нь олгосон халал гэрчилгээг хэсэгчлэн хуулбарлах, мөн/эсхүл уншигдах байдлыг нь төвөтэй болгох байдлаар хуулбарлах, гэрчилгээний эх хувь эсхүл хуулбарыг дуурailгах, халал баталгаажуулалтын байгууллагын хяналт, зөвшөөрөлгүйгээр гэрчилгээ, тайланг өөр хэл рүү орчуулж болохгүй.

8.5 Нууцлал

ISO/IEC 17021-1:2015-ын 8.4 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

8.6 Халал баталгаажуулалтын байгууллага болон түүний үйлчлүүлэгчид хооронд мэдээлэл солилцоо

ISO/IEC 17021-1:2015-ын 8.5 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

9 ҮЙЛ ЯВЦЫН ШААРДЛАГУУД

9.1 Ерөнхий шаардлагууд

9.1.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын хамрах хүрээг халал бүтээгдэхүүн/үйлчилгээний ангилалууд (жишээ нь анхдагч (түүхий эд, завсарын бүтээгдэхүүн) үйлдвэрлэл, хүнсний боловсруулалт, сав баглаа боодлын материал үйлдвэрлэл зэрэг)-тай холбоотойгоор, мөн А хавсралтийн дагуу ангилал, салбаруудыг нарийвчлан тодорхойлно.

9.1.2 Халал баталгаажуулалтын байгууллага нь аудит хийх өдөр, цаг, улирал сонгох үйл явцыг хийдэг байх бөгөөд ингэснээр аудитын баг нь хамрах хүрээнд багтах төлөөлөхүйц хангалттай хэмжээний үйлдвэрлэлийн шугам, ангилал, салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагад аудит хийх боломжийг олгох юм. Хэрэв баталгаажуулалтанд хамрах зүйл нь нь халал бүтээгдэхүүний баталгаажуулалт байгаа тохиолдолд халал баталгаажуулалтын байгууллага нь үйлдвэрлэж байгаа буюу санал болгож буй бүтээгдэхүүний халал байдалд хийсэн лабораторийн шинжилгээний хариуг хянана.

9.1.3 Аудитын хөтөлбөрт хоёр үе шат бүхий үндсэн аудит, эхний болон хоёр дахь жилийн магадлах хяналтын аудит, мөн баталгаажуулалтын хугацаа дуусахын өмнөх буюу гурав дахь жилийн давтан баталгаажуулалтын аудитаас бүрдэнэ. Гурван жилийн баталгаажуулалтын мөчлөг нь баталгаажуулалт эсхүл давтан баталгаажуулах шийдвэрээс эхлэнэ. Аудитын хөтөлбөр болон аливаа нэмэлт запруулгыг товлоходоо үйлчлүүлэгч байгууллагын хэмжээ, менежментийн тогтолцооных нь хамрах хүрээ болоод нарийн төвөтэй байдал, бүдээгдэхүүн ба үйл явц, менежментийн тогтолцооны үр нөлөөний түвшин, өмнөх аливаа аудитын үр дүнг харгалзан үзнэ. Хэрэв халал баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгчийн хэдийнээ хийлгэсэн баталгаажуулалт, өөр бусад аудитыг харалзаж үздэг тохиолдолд баталгаажуулахад хангалттай, батлах боломжтой мэдээллийг цуглуулж, аудитын хөтөлбөрт хийгдсэн аливаа запруулгыг бүртгэнэ. Гэрчилгээний хүчинтэй хугацаа нь халал бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалтын схемээр тодорхойлогдох бөгөөд баталгаажуулагдсан

байгууллага нь OIC/SMIIC-ийн халал стандарт, холбогдох шаардлагуудыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд ямар ч үед түдгэлзүүлэх буюу цуцлана.

9.1.4 ISO/IEC 17021-1:2015-ын 9.1.3, 9.1.4 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

9.1.5 Халал баталгаажуулалтын байгууллага нь аудитын хугацааг тодорхойлолх баримтжуулсан журамтай байх бөгөөд халал баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч бүрийн бүтээгдэхүүн/үйлчилгээний мөн/эсхүл ХАБМТ-д бүрэн гүйцэт, үр дүнтэй аудитыг төлөвлөх, гүйцэтгэхэд шаардлагатай хугацааг тодорхойлно. Халал баталгаажуулалтын байгууллагын тодорхойлсон аудитын хугацаа, тодорхойлсон үндэслэлийг бүртгэнэ. Аудитын хугацааг тодорхойлоходоо Халал баталгаажуулалтын байгууллага нь В хавсралтыг харгалзан үзэх бөгөөд дараах нөхцлүүдийг хангана:

- a) OIC/SMIIC-ийн халал стандартын шаардлагууд,
- b) байгууллагын хэмжээ, төвөгшилтэй байдал,
- c) технологийн болон зохицуулалтын нөхцөл,
- d) үйлдвэрлэл, үйл явц эсхүл ХАБМТ-ны хамрах хүрээнд хамаарах аливаа үйл ажиллагаанд аутсорсинг байгаа эсэх,
- e) өмнө нь хийлгэсэн аливаа аудитын үр дүн,
- f) үйлдвэрлэлийн байршлын тоо болон олон ажлын байрыг харгалзан үзэх.

9.1.6 Баталгаажуулалт хийлгэх гэж буй олон ажлын байршил бүхий байгууллагын ажлын байр бүр тусдаа үнэлгээ, баталгаажуулалт хийлгэх шаардлагатай.

9.1.7 ISO/IEC 17021-1:2015-ын 9.2.3.3, 9.2.3.4, 9.2.3.5, 9.4.1-9.4.7 хоорондох заалтууд болон ISO/IEC 17065:2012-ын 7.2-7.4 хоорондох заалтуудад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

9.1.8 Халал баталгаажуулалтын байгууллага нь хийсэн аудит бүрийн тайланг бичгэн хэлбэрээр өгнө. Тус тайлан нь ISO 19011-д заасан холбогдох зөвлөмжид үндэслэн хийгдэнэ. Аудитын баг нь сайжруулалт хийх боломжийг тодорхойлох боломжтой боловч зөвлөгөө гэж тооцогдох тодорхой шийдлийг зөвлөх ёсгүй. Аудитын тайлангийн эзэмшигч нь Халал баталгаажуулалтын байгууллага байна. Хэрэв бүтээгдэхүүн/үйлчилгээ нь хүнсний хэлхээний үйл ажиллагаанд хамаарах тохиолдолд тайланд ХАБМТ-той холбоотой асуудлуудыг тусгасан байна.

9.1.9 Баталгаажуулалтын шийдвэр гаргахад ISO/IEC 17021-1:2015-ын 9.4.9, 9.4.10, 9.5.1-9.5.3 хоорондох заалтууд болон ISO/IEC 17065:2012-ын 7.5, 7.6 дахь заалтуудад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

9.2 Анхан шатны аудит ба халал баталгаажуулалт

9.2.1 Өргөдөл гаргах

a) ISO/IEC 17021-1:2015-ын 9.1.1 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

b) Халал баталгаажуулалтын байгууллага нь өргөдөл гаргагч байгууллагаас хууль эрх зүйн байдал/аж ахуйн нэгжийн турай, түүхий эд, боловсруулалтын шугам, ХАБМТ-той холбоотой асуудлууд буюу НАССР-ын судалгаа, ээлжийн тоо болон ээлж тус бүр дэх ажиллагсдын тоо гэх зэрэг мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар өгөхийг шаардана.

9.2.2 Өргөдлийг дүн шинжилгээ

ISO/IEC 17021-1:2015-ын 9.1.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд хамаарна.

ТАЙЛБАР – Аудитын явцад үл тохирол илэрсэн тохиолдолд үйлдвэрлэгч/үйлчилгээ үзүүлэгч нь дахин аргадал гаргахаасаа өмнө аудитын явцад илэрсэн бүх үл тохиролыг бүрэн гүйцэт арилгасан талаарх мэдэгдлийг гаргана. Баталгаажуулалтын үйл явц амжилтгүй болсоны дараа тухайн мэдэгдлийг гаргасан тохиолдолд л дахин өргөдөл хүлээж авна. Амжилтгүй болсон эхний өргөдлийг баталгаажуулалтын өөр байгууллагад гаргасан тохиолдолд өргөдөл гаргач нь баталгаажуулалт хийлгэх эхний өргдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө.

9.2.3 Халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явцад хийгдэх анхдагч баталгаажуулалтын аудит нь нэг ба хоёрдугаар гэсэн хоёр үе шаттай зохион байгуулагдана.

9.2.3.1 Нэгдүгээр шатны аудит

9.2.3.1.1 ISO/IEC 17021-1:2015-ын 9.1.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагууд болон хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлсэн хяналтын арга хэмжээг хослуулан хэрэгжүүлсэн тохиолдолд аудитын нэгдүгээр үе шат нь халал шаардлага ХАБМТ-д багтаасан баримт бичгийг хянаж, халал стандартын шаардлагуудад нийцүүлэн боловсруулсан эсэх, мөн шинэчлэлийг цаг тухайд нь хийдэг эсэхэд үнэлгээ өгнө.

Баталгаажуулалтын баримт бичиг нь үндэсний болон олон улсын эрх зүйн баримттай хэрхэн уялдаж байгаа эсэхийг шалгана.

9.2.3.1.2 Нэгдүгээр шатны аудитын зорилго нь үйлдвэрлэгчийн хүнсний аюулгүй байдал, Халал тодорхойлолт, шинжилгээ, НАССР, Халал Хяналтын төлөвлөгөө, урьдчилсан нөхцөл хөтөлбөрүүд, бодлого болон зорилтууд, ХАБМТ, Халал үйлдвэрлэлийн явцыг хянах байгууллагын дотоод аудитын дүнг үндэслэн хоёрдугаар шатны аудитыг төлөвлөнө. Үүнд:

- тухайн байгууллага нь хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн бизнестээ тохирсон урьдчилсан нөхцөлт хөтөлбөрүүдийн боловсруулалт (хууль эрх зүй зохицуулалтын шаардлагууд),
- ХАБМТ, Халал менежментийн тогтолцоо нь байгууллагын хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналт, үйл явцын үнэлгээг багтаасан байдал,
- хүнсний аюулгүй байдалтай холбогдолтой хууль тогтоомжтой эсэх,
- ХАБМТ эсвэлл Халал менежментийн тогтолцоо нь байгууллагын хүнсний аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдал,
- ХАБМТ, Халал менежментийн тогтолцоо, Халал стандартыг хэрэгжүүлэх хөтөлбөр нь аудит (хоёрдугаар шатны)-ыг гүйцэтгэх үндэслэл болох эсэх,
- ХАБМТ, Халал менежментийн тогтолцооны стандартын шаардлагад нийцсэн сайжруулах хөтөлбөрүүдтэй эсэх,
- ХАБМТ эсвэл Халал менежментийн тогтолцооны баримт бичиг нь байгууллага дотроо болон холбогдох ханганд нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид болон сонирхогч талуудтай харилцах зохицуулалттай эсэх,
- Аудитад шаардлагатай нэмэлт баримт бичгүүд.

ТАЙЛБАР -Халал стандарт гэдэг нь OIC/SMIIC-ийн стандарт, ИОСХЗХ-ийн баталсан ямар ч Халал стандарт байж болно.

9.2.3.1.3 Нэгдүгээр шатны аудитын зорилтыг хангах үүднээс Халал баталгаажуулалтын нэгдүгээр шатыг халал баталгаажуулалтын байгууллагын ажлын байранд эсвэл өргөдөл гаргагчийн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран ажлын байранд гүйцэтгэж болно.

a) A, B, E, F, G, H, J ангилал (A хавсралт)-ын хувьд, нэгдүгээр шатны аудитыг ажлын байранд гүйцэтгэх албагүй. Шаардлагатай гэж үзвэл аудитын багийн шийдвэрээр аудитыг ажлын байранд хийж гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэнэ. C, D, I, K, L (A хавсралт)-ын хувьд нэгдүгээр шатны аудитыг заавал ажлын байранд гүйцэтгэнэ.

b) Нэгдүгээр шатны аудитыг ажлын байран дээр гүйцэтгээгүй тохиолдолд тухайн шатны аудитын үргэлжлэх хугацаа нь аудитын нийт хугацааны 20%-иас хэтрэх ёсгүй (B хавсралт). Халал баталгаажуулалтыг үйлдвэр, үйлчилгээний байранд хийсэн тохиолдолд 1-р шатны аудитын үргэлжлэх хугацаа нь нийт хугацааны 30%-иас хэтрэх ёсгүй. (B хавсралт)

9.2.3.1.4 Нэгдүгээр шатны аудитын явцыг баримтжуулж, үйлчлүүлэгчид мэдээлэх бөгөөд илэрсэн үл тохирлууд нь хоёрдугаар шатны аудитын явцад үзүүлэх нөлөөлөлийн талаар тодорхой зааж өгнө.. Өргөдөл гаргагч талд нэгдүгээр шатны аудитын үр дүн хоёрдугаар шатны аудитыг хойшлуулах, цуцлахад хүргэж болзошгүй болохыг мэдэгдэнэ.

9.2.3.1.5 Нэгдүгээр шатны аудит хийлгэж өргөдөл гаргагч буй ХАБМТ, Халал менежментийн тогтолцоо ,холбогдох Халал стандартын шаардлагуудыг бүрэн үр дүнтэй хэрэгжүүлж нийцэж байгааг тогтоосон тохиолдолд хоёрдугаар шатны аудитаар тэдгээрийн аль ч хэсэгт давтан аудит хийх шаардлагагүй. Аудит хийлгэсэн ХАБМТ нь Халал баталгаажуулалтын байгууллагын баталгаажуулалтын шаардлагыг хангаж цаашид мөрдлөг болгон ажиллана. Энэ тохиолдолд хоёрдугаар шатны аудитын тайланд үл тохирлын илрүүлэлтийг багтааж, нэгдүгээр шатны аудитаар тэдгээрийн үл тохирлыг тогтоосон талаар тодорхой дурьдсан байна.

9.2.3.1.6 ISO/IEC 17021-1:2015-ын 9.3.1.2.4 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

Нэгдүгээр шат болон хоёрдугаар шатны аудит хоорондын зайд нь 6 сараас дээшгүй байна Хэрэв аудит хооронд урт хугацаа шаардлагатай бол нэгдүгээр шатны аудитыг давтан гүйцэтгэнэ.

9.2.3.2 Хоёрдугаар шатны аудит

ISO/IEC 17021-1:2015-ын 9.3.1.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.2.4 Халал анхдагч баталгаажуулалтын аудит, түүний дүгнэлт

ISO/IEC 17021-1:2015-ын 9.3.1.4 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.2.5 Халал анхдагч баталгаажуулалтын гэрчилгээн дэх мэдээлэл

ISO/IEC 17021-1:2015-ын 9.5.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.2.6 Дээж авах

9.2.6.1 Шаардлагатай тохиолдолд аудитын баг хяналт, сорилт шинжилгээ хийхийн тулд үйлдвэрлэл, үйлчилгээний байрнаас хүрэлцэхүйц хэмжээний дээж авна.

9.2.6.2 Халал бүтээгдэхүүний баталгаажуулалтыг халал бүтээгдэхүүний багц үйлдвэрлэлийн сорилт шинжилгээ, хяналт, статистикаар батлагдсан бодит байдлын түвшинд үндэслэн нийцүүлэх арга барилыг ашиглан, дээж авч тогтоосон хуваарийн дагуу хийнэ. Халал баталгаажуулалтын байгууллага нь дээж авах аливаа шаардлагыг тогтооходо дээжийг мөшгөх үйл явц болон халал бүтээгдэхүүний төлөөлөл мөн болохыг нотлох, дээжийг сонгох, хянах аргыг тодорхойлсон журмыг боловсруулан мөрдөнө.

9.2.6.3 Аудитын багийн цуглуулсан халал бүтээгдэхүүний төлөөлөл болох дээжийг ISO/IEC 17025-ын дагуу итгэмжлэгдсэн болон халал эрх бүхий байгууллагын баталгаат лабораторид шинжлүүлнэ

9.2.7 Хяналт, сорилт шинжилгээ

9.2.7.1 Халал бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага хяналт, сорилт шинжилгээ нь үндэсний болон бүсийн, олон улсын хуулийн заалтад нийцсэн байна.

9.2.7.2 Хяналт, сорилт шинжилгээ хийдэг лабораториуд нь ISO/IEC 17025-ын дагуу итгэмжлэгдсэн эсвэл халал эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн байна

9.2.7.3 Хөндлөнгийн шинжилгээ хийх байгууллага байхгүй тохиолдолд нийлүүлэгчийн шинжилгээний лаборатори нь шаардлага хангах эсэхийг баталгаажуулалтын байгууллага хянах ба баталгаажуулалтын үр дүн бодит байдалд нийцэж итгэлцэлийг төрүүлэхүйц байх ёстой.

9.2.8 Аудитын тайлан

9.2.8.1 Баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллагад аудит тус бүрийн тайланг бичгээр гаргаж өгнө. Аудитын баг сайжруулах боломжийн талаар тодруулга өгөх ба тодорхой шийдлийг санал болгохгүй. Аудитын тайланг баталгаажуулалтын байгууллага хадгална.

9.2.8.2 Аудитын багийн ахлагч нь тайлангийн агуулгыг хариуцна. Баталгаажуулалтын үнэн зөв шийдвэрийг гаргах явдлыг хангахын тулд багийн ахлагч аудитын тайланд аудитын талаарх тодорхой, товч, ойлгомжтой мэдээллийг тусгасан байна. Тайланд дараах агуулгыг тусгасан байна:

- Халал баталгаажуулалтын байгууллагын нэр, бэлэг тэмдэг,
- үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн нэр, хаяг,
- аудитын төрөл (үндсэн, магадлах хяналт, давтан баталгаажуулалтын, тусгай, багц бүтээгдэхүүний баталгаажуулалтын аудит)

- d) баталгаажуулалтын төрөл (багцын, онцгой бүтээгдэхүүн, үйл явц, цуврал үйлдвэрлэл),
- e) аудитын стандарт, лавлагааны баримт бичиг,
- f) аудитын хамрах хүрээ, ялангуяа байгууллагын үйл ажиллагааны нэгж , аудит хийлгэж буй үйл явц, аудитын хугацааг тодорхойлох,
- g) аудитын хөтөлбөр төлөвлөгөөнөөс өөрчлөгдсөн эсэх, тийм бол түүний шалтгаан,
- h) аудитын багийн бүрэлдэхүүний үүрэг хариуцлагыг тодорхойлох, (багийн ахлагч, багийн гишүүд, техникийн эксперт(үүд) Исламын шашны эксперт болон Халал итгэмжлэлийн байгууллагаас дагалдаж буй хүмүүс (ажиглагч(ид), зохицуулах байгууллага, Халал баталгаажуулалтын схем эзэмшигч гэх мэт),
- i) Халал баталгаажуулалтын аудитын хамрах хүрээ, хийгдсэн огноо болон байршил (ажлын байр дээр ажлын бус байршил, байнгын эсвэл түр байршил),
- j) хэрэв боломжтой бол аудитын ажиллагааг зайнаас хийж болно. хамааралтай эсхүл,
- k) аудитын тайлан нь (9.2.4-ийг үзнэ үү), нотлох баримт ба дүгнэлтийн лавлагаа, аудит, стандарт холбогдох норматив баримт бичгийн шаардлагыг мөрдлөг болгоно,
- l) аудит нь боломжит мэдээллээс түүвэрлэх үйл явц дээр тулгуурласан болохыг тусгасан тухай мэдэгдэл,
- m) шаардлагатай бол Халал баталгаажуулалтын баримт бичиг, Халал тэмдэг, бэлэг тэмдэг
- n) шаардлагатай бол өмнө нь илрүүлсэн үл тохиролтой холбоотой хийсэн залруулах арга хэмжжэний үр дүнгийн баталгаа, ,
- o) шаардлагатай бол Халал менежментийн тогтолцоотой холбоотой нотлох баримтын хураангуй, үр дүнгийн мэдэгдэл,
- Халал менежментийн тогтолцооны холбогдох шаардлага, хүлээгдэж буй үр дүнд хүргэх боломж чадвар,
- Дотоод аудит болон удирдлагын лүн шинжилгээний үйл явц,
- p) гэрчилгээний хамрах хүрээний зохистой байдал, дүгнэлт,
- q) дараагийн аудит хийлгэх санал, жишээ нь шийдвэрлэх шаардлагатай чухал эзэгтэй асуудлууд, анхааралд авах зүйлс гэх зэрэг,
- r) аудитын багийн халал баталгаажуулалттай холбоотой зөвлөмж (гэрчилгээ олгох, хадгалах, шинэчлэх, хамрах хүрээг нэмэх, хасах, түдгэлзүүлэх, цуцлах гэх мэт).

9.3 Магадлан хяналтын үйл ажиллагаа

ISO/IEC 17021-1:2015-ын 9.6.2 дахь заалт, ISO/IEC 17065:2012-ын 7.10 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.3.1 Халал баталгаажуулалтын байгууллага нь тодорхой хугацааны давтамжтайгаар магадлах хяналт явуулж, халал бүтээгдэхүүн, үйлчилгээ нь баталгаажуулалтын шаардлагад үргэлжлүүлэн нийцэж байгааг шалгадаг байна. Тухайн халал бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн шинж, баталгаажуулалтын шаардлага стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд анхаарал хандуулж,

халал бүтээгдэхүүн, үйлчилгээнд илэрсэн ямар нэг үл тохирол, баталгаажсан халал бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гомдол гарсан зэрэгт анхаарна.

9.3.2 Халал бүтээгдэхүүн, үйлчилгээний байранд аудит хийх явцад халал бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд шууд нөлөөлөх үл тохирол илэрсэн тохиолдолд магадлан хяналтын зорилгоор дээж авна.

9.3.3 Аль ч тохиолдолд магадлан хяналтын үр дүнгийн тайлантай холбоотой журмыг шийдвэр гаргагч(ид) гаргана.

9.4 Давтан баталгаажуулалт

ISO/IEC 17021-1:2015-ын 9.6.3 дахь заалтуудад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.4.1 Халал гэрчилгээг түдгэлзүүлэгүй, цуцлаагүй л бол давтан баталгаажуулалтын үйл ажиллагааг шинэчлэн хийнэ.

9.4.2 Гэрчилгээгээ шинэчлээгүй бол халал гэрчилгээ эзэмшигч нь халал тэмдгийг өөрийн байр эсхүл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дээр хэрэглэхийг хориглоно.

9.5 Тусгай аудит

ISO/IEC 17021-1:2015-ын 9.6.4 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.6 Халал баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах буюу хамрах хүрээг багасгах

ISO/IEC 17065:2012-ын 7.11 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.7 Зарга, гомдол

ISO/IEC 17021-1:2015-ын 9.7, 9.8 дахь заалтуудад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.7.1 Халал баталгаажуулалттай холбоотой зарга, гомдлыг халал баталгаажуулалтын байгууллагад гаргана. Энэ тохиолдолд гомдлыг барагдуулж, холбогдох мэдээллийг талуудад өгөх үүрэгтэй хүсэлт гомдол хариуцсан хороог байгууна.

9.7.2 Тус хорооны гишүүд нь өргөдөл гомдлын агуулгатай холбоотой халал баталгаажуулалтын ажлаас хараат бус байна.

9.7.3 Тус хороо нь доод тал нь гурван (3) гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг нь Исламын шашны эксперт байна. Гомдолтой холбоотой шийдвэрийг олонхийн саналаар бус нэгдсэн саналаар шийдвэрлэнэ.

9.7.4 Халал бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдээс ирэх гомдлыг халал баталгаажуулалтын байгууллага хүлээн авч шаардлагатай шалгалт судалгааг хийх үүрэгтэй. Тус үнэлгээний үр дүнд гомдол батлагдсан тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гэрээний холбогдох заалтын дагуу учирсан хохирлыг барагдуулах үүрэгтэй.

9.8 Өргөдөл гаргагч, үйлчлүүлэгчдийн бүртгэл

ISO/IEC 17021-1:2015-ын 9.9 дэх заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

9.9 Баталгаажуулалтад нөлөөлөхүйц өөрчлөлтүүд

ISO/IEC 17065:2012-ын 7.10 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10 БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ШААРДЛАГУУД

10.1 Ерөнхий зүйл

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.1 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.2 Менежментийн тогтолцооны гарын авлага

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.2 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.3 Баримт бичгийн хяналт

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.3 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.4 Бүртгэлийн хяналт

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.4 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.5 Удирдлагын дүн шинжилгээ

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.5 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.6 Дотоод аудит

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.6 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.7 Залруулах үйл ажиллагаа

ISO/IEC 17021-1:2015-ын 10.2.7 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

10.8 Сэргийлэх үйл ажиллагаа

ISO/IEC 17065:2012-ын 8.8 дахь заалтад тодорхойлсон бүх шаардлагуудыг хангасан байна.

**А хавсралт
(норматив)**

**Халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц/
менежментийн тогтолцооны ангилал**

Халал баталгаажуулалтын байгууллага Хүснэгт А.1-ийг мөрдөж ашиглана.

- а) баталгаажуулалт гүйцэтгэх ажлынхаа хамрах хүрээг тодорхойлох,
- б) өөрийн аудиторууд, экспертууд, ажилтнуудаас Халал баталгаажуулалтын тогтолцоон дахь тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах чадамж, техникийн мэргэшлийг тодорхойлох,
- с) зохих мэргэшил туршлагатай аудитын багийг сонгох.

Хүснэгт А.1-д дурьдсан жишээнүүд зөвхөн холбогдох сэдвийн заалт юм. Зарим тодорхой үйлчлүүлэгч байгууллагын хамрах хүрээ нь нэгээс дээш ангилалыг хамаарч болно.

**Хүснэгт А.1 – Халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц/
менежментийн тогтолцооны ангилал**

Кластр^a	Ангилал	Дэд ангилал		Хамаарах үйл ажиллагааны жишээ
A	A I Мал аж ахуй, амьтаны ферм	AI	Мах, сүү, өндөг, зөгийн балны чиглэлийн мал, амьтаны аж ахуй эрхлэх	Мах, өндөг, сүү эсхүл зөгийн балны үйлдвэрлэлийн зорилгоор мал, амьтаныг (загас, далайн амьтанаас бусад) үржүүлэх Өсгөх, тэжээх, барих, агнах (агнасан газраа төхөөрөх) Тухайн аж ахуйн савлалт ^b , хадгалалт
	A II Загас, далайн гаралтай хүнсий аж ахуй эрхлэх	All	Загас, далайн гаралтай хүнсий аж ахуй эрхлэх	Мах үйлдвэрлэлд ашиглах загас, далайн амьтадыг үржүүлэх Өсгөх, барих, загасчлах (барьсан газраа төхөөрөх) Тухайн аж ахуйн савлалт ^b , хадгалалт
B	Газар тариалан, ургамлын аж ахуй	BI	Газар тариалан, ургамлын аж ахуй эрхлэх (үр тариа, бусад)	Ургамал тариалах, ургац хураах (үр тариа, олон төрлийн шошноос бусад), цэцэрлэгжүүлэлтийн аж ахуйн бүтээгдэхүүн (жимс, ногоо, амтлагч, мөөг г.м), хүнсэнд хэрэглэдэг усны ургамал Тухайн аж ахуйн савлалт ^b , хадгалалт

		BII	Үр тариа, төрөл бүрийн шошны аж ахуй эрхлэх	Үр тариа, олон төрлийн шошыг хүнсний зориулалтаар тариалах, ургац хураах Тухайн аж ахуйн савлалт ^b , хадгалалт
C	Хүнс үйлдвэрлэл	CI	Халал аргаар төхөөрөх, мал, амьтаны гаралтай түргэн муудах бүтээгдэхүүн боловсруулалт	Мал, амьтаны гаралтай бүтээгдэхүүн, үүний дотор загас, далайн гаралтай амьтад, өндөг, сүү, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жижиглэх, савлах
		CII	Ургамлын гаралтай түргэн муудах бүтээгдэхүүн боловсруулалт	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн, үүний дотор жимс, шинж шүүс, ногоо, үр тариа, самар, олон төрлийн шош үйлдвэрлэл
		CIII	Мал, амьтаны болон ургамлын гаралтай түргэн муудах бүтээгдэхүүн боловсруулалт (маханд суурилсан хүнс, холимог бүтээгдэхүүн)	Мал, амьтан болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн, үүний дотор пицца, лазанья, сэндвич, банш, идэхэд бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
		CIV	Орчиндоо тогтвортой бүтээгдэхүүн	Гадаад орчны температурт хадгалж, худалдаалдаг ямар ч эх үүсвэрээс гаралтай Халал хүнсний бүтээгдэхүүн, үүний дотор лаазалсан хүнс, жигнэмэг, хөнгөн зууш, тос, ундны ус, ундаа, гоймон, гурил, элсэн чихэр, хүнсний давсны үйлдвэрлэл
D	Мал, амьтаны тэжээл үйлдвэрлэл	DI	Тэжээл үйлдвэрлэл	Хүнсний зориулалттай мал, амьтанд зориулсан хүнсний нэг эсхүл олон эх үүсвэрээс гаралтай тэжээл үйлдвэрлэл
		DII	Гэрийн тэжээмэл амьтаны хоол үйлдвэрлэл	Хүнсний зориулалттай бус мал, амьтанд зориулсан хүнсний нэг эсхүл олон эх үүсвэрээс гаралтай тэжээл үйлдвэрлэл
Катеринг	E	Катеринг		Халал хүнснийг хэрэглээнд зориулж бэлтгэх, хадгалах, тохиromжтой бол бэлтгэсэн газар, өөр байршил эсхүл зоогийн газруудад хүргэх
Жижиглэх худалдаа, тэвээрлэлт, хадгалалт	F	F1	Жижиглэн, бөөний худалдаа	Хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчдэд (жижиглэн худалдааны төв, дэлгүүр, бөөний худалдааны төв) хангах
		FII	Хүнсний брокер/худалдаа	Өөрийн нэр дээр эсхүл бусдад зуучлах замаар хүнсний бүтээгдэхүүнийг худалдаж авах, худалдах

					Холбогдох сав, баглаа, боодол ^b
G	Тээвэр, агуулахын үйлчилгээ	GI	Tүргэн мууддаг, орчиндоо тогтвортой хүнс, тэжээлийг тээвэрлэлт, хадгалалтын үйлчилгээ	Aмархан мууддаг хүнс, тэжээлийг хадгалах агуулахын байр, түгээлтийн тээврийн хэрэгсэлт	Холбогдох сав, баглаа, боодол ^b
			GII	Орчиндоо тогтвортой хүнс, тэжээлийг тээвэрлэлт, хадгалалтын үйлчилгээ	Орчиндоо тогтвортой хүнс, тэжээлийг хадгалах агуулахын байр, түгээлтийн тээврийн хэрэгсэл
Туслах үйлчилгээ	Үйлчилгээ	HI			Хүнсний аюулгүй байдал, түүний дотор усны хангамж, хортон шавьжийн устгал, цэвэрлэгээ, хог хаягдал зайлцуулахтай холбоотой үйлчилгээ үзүүлэх
			HII	Санхүүгийн үйлчилгээ	Банк, даатгал, хөрөнгө оруулалтын сан, лизинг, бартер гэх мэт
			HIII	Мусульман шашинд ээлтэй аялал жуулчла, аялалтай холбоотой үйлчилгээ	Амралтын газар, зочид буудал, аялал жуулчлал, аялалын агентлагийн үйлчилгээ, жишээ нь захиалга хийх г.м
		I	Хүнсний сав, баглаа, боодол болон сав, баглаа, боодлын материал үйлдвэрлэл	Хүнсний сав, баглаа, боодлын материалын үйлдвэрлэл	
		J	Тоног төхөөрөмж үйлдвэрлэл		Хүнс боловсруулах тоног төхөөрөмж, автомат машины үйлдвэрлэл, хөгжүүлэлт
Биохимийн	K	(Био)химийн бодис үйлдвэрлэл			Хүнс, тэжээлийн нэмэлт, витамин, эрдэс, био-өсгөвөр, амт оруулагч, фермент, боловсруулалтын туслах материал болох Пестицид, эм, бордоо, цэвэрлэгээний бодисын үйлдвэрлэл
Бусад	Бусад материалын үйлдвэрлэл	L	ЛI	Гоо сайхан	-----
			LII	Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	-----
			LIII	Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн	-----
			LIV	NEC (өөр хаана ч ангилаагүй)	-----

^a “Кластр”-ийг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн хамрах хүрээ, баталгаажуулалтын байгууллагыг гэрчлэх итгэмжлэлийн байгууллагуудад хэрэглэхээр зориулагдсан.

^b “фермийн савлалт” нь бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулалгүй, боловсруулалт хийлгүйгээр савлахыг хэлнэ.

с “холбогдох сав, баглаа, боодол” бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулалгүй, боловсруулалт хийлгүйгээр, үндсэн сав, баглаа, боодлыг нь өөрчлөлгүйгээр савлахыг хэлнэ.

СТАНДАРТЫН ТӨСӨЛ

В хавсралт (мэдээллийн)

Аудит хийх доод хугацаа

B.1 Ерөнхий зүйл

Халал баталгаажуулалтын байгууллага нь тус стандартын 9.1.4 дэх хэсэг болон ISO/IEC 17021-1-т заасны адил ажлын байр бүр дээр шаардлагатай аудитын үргэлжлэх хугацааг тодорхойлоходоо, B.1 хүснэгтэд харуулсан анхдагч баталгаажуулалтын зорилгоор ажлын байран дээрх хийх аудитын доод хугацааг мөрдөнө. Хамгийн бага хугацаа гэдэгт анхдагч баталгаажуулалтын аудитын 1-р болон 2-р үе шат (9.2.3-ыг үзнэ үү)-үүд хамаарах боловч аудитад бэлтгэх хугацаа болон аудитын тайлан боловсруулах хугацаа тус тусороогүй болно.

Магадлан хяналтын аудит хийх доод хугацаа нь үндсэн аудитын хугацааны 1/3 байх бөгөөд доод тал нь 0.5 аудит өдөр байна. Хамгийн доод шинэчлэх хугацаа нь анхан шатны аудитын хугацааны 2/3 байх бөгөөд доод тал нь 0.5 аудит өдөр байна.

Холбогдох баталгаажсан Халал бүтээгдэхүүн/ үйлчилгээ/ үйл явц/ менежментийн тогтолцоо байхгүй тохиолдолд аудитын үргэлжлэх хугацааг нэмнэ. Менежментийн тогтолцооны гэрчилгээ нь холбогдох бүтээгдэхүүн/ үйлчилгээний хүнсний аюулгүй байдлын асуудлын хамрах хүрээг багтаасан байна.

Баталгаажуулалтын хамрах хүрээтэй уялдуулан ажилчдын тоог бүтэн цагаар ажилладаг ажилчдын тоонд дүйцүүлэн илэрхийлнэ.

Олон ажлын байрны сонголтын A, B, E, F, G (Хүснэгт B.2-ыг үзнэ үү) ангилалаас, мөн эдгээр ангиллын хүрээнд ойролцоо үйл ажиллагаа эрхэлдэг 20-оос дээш ажлын байр бүхий байгууллагагуудад хийхэд тохиромжтой. Энэ нь үндсэн баталгаажуулалт, магадлах хяналт болон давтан баталгаажуулалтын аудитуудад хамаарна. Баталгаажуулалтын байгууллага нь олон ажлын байрны сонголтын шийдвэрийн үндэслэлээ гаргах шаардлагатай.

Бүтээгдэхүүний төрлийн тоо, бүтээгдэхүүний шугамын тоо, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Халал эгзэгтэй цэгийн хяналт (CCP), ашиглагдаж буй урьдчилсан нөхцөлт хөтөлбөрийн тоо, барилгын орчин, дэд бүтэц, дотоод дахь лабораторийн шинжилгээний хэмжээ бусад хүчин зүйлийн улмаас аудит хийх доод хугацааг нэмэгдүүлж болно.

Бүх төрлийн аудитын хугацаанд үйлчлүүлэгчийн байршилд зарцуулсан нийт цаг (газар дээр нь болон онлайнаар) болон төлөвлөгөө гаргах, баримт бичиг хянах, үйлчлүүлэгчийн ажилчидтай харилцах, тайлан бичих зэрэг ажлын бус байран дээр зарцуулсан хугацаа багтана.

Ажлын талбар дээр хийх Халал баталгаажуулалтын аудит нь B.2 дахь аргад үндэслэн тооцоолсон аудитын хугацааны 70%-аас доош байж болохгүй. Энэ нь үндсэн, магадлах хяналт болон давтан баталгаажуулалтын аудитад хамааралтай. Халал баталгаажуулалтын байгууллага нь зохих, холбогдох үндэслэлээ гаргаснаар аудитын хугацааг багасгах эсвэл нэмэх хүсэлт гаргаж болно. Энэхүү багасгасан хэмжээ нь Хэсэг B.2-ын дагуу аудитын нийт хугацааны 30%-иас хэтрэгүй байна..

B.2 Анхдагч баталгаажуулалтын аудит хийх доод хугацааг тооцоолох

B.2.1 Нэг ажлын байранд аудит хийх доод хугацаа, **Ts:**

$$Ts = TD + TH + (TPV + TFTE)^{**}CC$$

Энд

TD бол ажлын байран дээр хийгдэх энгийн аудитын хугацаа, өдрөөр;

TH бол нэмэлт НАССР (Халал CPP) бүтээгдэхүүний бүлгийн судалгааны аудитын өдөр бөгөөд зөвхөн хүнсний хэлхээний бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлэгт хамаарна. Компани хувьд НАССР Халал CPP -ын нэг судалгааны Н үсэг нь “0” утгатай байна. Нэмэлт судалгаа тутамд аудитын өдөр нэмэгдэх бөгөөд өөр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд үүнийг “0” гэж авч үзэж болно.

TPV бол бүтээгдэхүүний төрлийн аудитын хугацаа

TFTE бол ажилчдын тоонд харьцах аудитын өдрийн тоо

CC бол үйлдвэрлэлийн нарийн төвөгтэй байдлын бүлгийн үргүүлэгч хүчин зүйл

TS-ийг тооцоолсоны дараа хариу нь бутархай тоо гарч байвал өдрийн тоог хамгийн ойр хагас өдөр руу эмхэтгэнэ. (жишээ нь 5.3 аудит өдөр 5.5 болж, 5.2 аудит өдөр 5 аудит өдөр болно).

TS-ийг тооцоолсоны дараа хариу бутархай тоо гарч байвал өдрийн тоог дараагийн бүтэн эсхүл хагас өдөр руу ахиулж бүхэл болгон эмхэтгэнэ. (жишээ нь 5.3 аудит өдөр 5.5 болж, 5.7 аудит өдөр 6 аудит өдөр болно)

B.2.2 Ажлын байр тус бүр дээр аудит хийх доод хугацаа, **Tasv**

$$Tasv = Ts * 50/100$$

Хүснэгт В.1 - Анхан шатны аудитын доод хугацаа

Ангила л Хавсралт А-г үзнэ үү		TD Ажлын байран дээрх энгийн аудит	TH* НАССР/ Халал судалгаа тус бүрийн (аудит өдрөөр)	TFTE Баталгаажуула лтын хамрах хүрээтэй холбоотой ажилтнуудын тоо (аудит өдрөөр)	CC Нарийн төвөгтэй бүлэг (хүчин зүйл, үргжүүлэгч)	TPV** Бүтээгдэх үүний төрөл зүйл (аудит өдрөөр)	Tasv Очсон нэмэлт ажлын байр бүрт (аудит өдрөөр)
A	AI	1.00	0.25				
	All	1.00	0.25				
B	BI	1.00	0.25				
	BII	1.00	0.25				
C	CI	1.50	0.50				
	CII	1.25	0.50				
	CIII	1.75	0.50				
	CIV	1.75	0.50				
D		1.50	0.25				
E		1.00	0.50				
F	FI	1.50	0.50				
	FII	1.25	0.50				
G	GI	1.50	0.50				
	GII	1.00	0.50				
H	HI	1.25	0.50				
	HII	1.75	0.50				
I		1.00	0.25				
J		1.00	0.25				
K		1.75	0.50				
L	LI	1.75	0.50				
	LII	1.25	0.25				
	LIII	1.50	0.50				
	LIV	1.00	0.25				
				1-ээс 19 = 0.5 20-оос 49 = 1.0 50-аас 79 = 1.5 80-аас 199 = 2.0 200-аас 499 = 2.5 500-аас 899 = 3.0 900-аас 1299 = 3.5 1300-аас 1699 = 4.0 1700-аас 2999 = 4.5 3000-аас 5000 = 5.0 > 5000 = 5.5	Бага СС=1.25 Дунд СС=1.50 Их СС=1.75 Маш их СС=2	1-ээс 3=0.50 4-ээс 6=1.00 7-оос 10=1.50 11-ээс 20=2.00 >20=3.00	Ажлын Б дээрх үнэлгээ/ауди тын цагийн 50%

* TH-ийг зөвхөн хүнсний хэлхээн дэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглана.

** TPV-ийг зөвхөн бүтээгдэхүүнд ашиглана.

Халал баталгаажуулалтын аудитад үндсээр нь нөлөөлөх байгууллагын үйл явц, үйлдвэрлэлийн шинж чанарын нарийн төвөгтэй байдлыг үндсэн дөрвөн бүлэг хувааж үзнэ.(Хүснэгт Б1)

Эдгээр нь:

- **Маш өндөр** - Ач холбогдол бүхий маш олон тооны нарийвчилсан дэд үйл явцууд (ихээхэн чухал халал бус эрсдэлтэй ихэвчлэн үйлдвэрлэгч,

боловсруулагч төрлийн байгууллагууд хамаарна. Үүнд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Халал талын болзошгүй эрсдэл маш өндөр, олон төрлийн үйл явц, дэд үйл явц, олон тооны түүхий эд материал, орцоос хамаарна);

- **Өндөр**- Ач холбогдол бүхий олон тооны үйл явцууд (халал бус эрсдэл ихтай ихэвчлэн үйлдвэрлэгч, боловсруулагч төрлийн байгууллагууд хамаарна. Үүнд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Халал талын болзошгүй эрсдэл өндөр, олон тооны үйл явц хамаарна);
- **Дундаж** - Ач холбогдол бүхий дундаж тооны үйл явц (ихэвчлэн үйлдвэрлэгч эсхүл үйлчилгээний байгууллагууд хамаарах бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь халал бус, болзошгүй эрсдэл дунд зэрэгтэй байна);
- **Бага** - Ач холбогдол бүхий цөөн тооны үйл явц (ихэвчлэн цөөхөн ач холбогдол бүхий байгууллагууд хамаарах бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь халал бус, болзошгүй эрсдэл багатай байна);

Хүснэгт Б1 нь нарийн төвөгтэй байдлын дээрх дөрвөн бүлгийг хамарна. Хүснэгт Б2 нь нарийн төвөгтэй байдлын дээрх хоёр бүлэг болон тухайн бүлэгт голдуу хамаарах үйлдвэрлэлийн салбар хоорондын холбоог харуулна.

Халал баталгаажуулалтын байгууллага нь тодорхой салбар дахь нарийн төвөгтэй байдлын бүлэгт хамаарах албагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Халал баталгаажуулалтын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллагын тодорхой үйл ажиллагааг нарийн төвөгтэй байдлын ангилалыг тодорхойлоход авч үзэх боломжийг хангах зорилгоор гэрээ, хяналтын журмаа уян хатан байлгана. Жишээ нь, химийн бодис үйлдвэрлэлийн салбар дахь олон байгууллага “өндөр нарийн төвөгтэй байдал”-тай гэдэг ангилалд хамаарах боловч химийн хариу урвал үзүүлдэггүй найруулалт хийдэг эрсдэл бүхий түүхий эдэд дэвшилтэт боловсруулалт хийдэг бол “дундаж”, магадгүй бүр “бага нарийн төвөгтэй байдал” гэдэг ангилалд хамруулах боломжтой.

Байгууллагын тогтолцоо бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх онцлог шинжийг харгалзан үзэж, үр дүнтэй аудит хийхэд аудитын хугацааг нэмэх эсхүл багасгах шаардлагыг нотлох хүчин зүйлд үндэслэн тохирох нийцүүлэлтийг хийнэ. Нэмэлт хүчин зүйлсийг хасагдах хүчин зүйлээр тэнцвэржүүлэх боломжтой. Аудитын хугацаатай холбоотой Хүснэгт Б1 болон Б2-т өгөгдсөн хугацаанд оруулсан нийцүүлэлт бүр дээр өөрчлөлтийн батлах хангалттай нотлох баримт, бүртгэлийг авна.

Хүснэгт Б.2 - Бизнесийн салбар болон нарийн төвөгтэй байдлын ангиллын хоорондын холбооны загвар

Төвөгшилтэй байдлын ангилал	Бизнесийн салбар
Mash өндөр	Өөр ангилалд багтаагүй (п.е.с) химийн бодис болон эмийн бүтээгдэхүүн, боловсруулсан махан бүтээгдэхүүн, генийн өөрчлөлтэй бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт, био өсгөвөр, гоо сайхны бүтээгдэхүүн, боловсруулалтын туслах нэмэлтүүд болон бичил биетүүд,

Өндөр	Төхөөрдөг мах, шувууны мах; бяслаг, жигнэмэг, хөнгөн зууш, тос, уух зүйлс, зочид буудал, зоогийн газрууд, хүнсний нэмэлт тэжээл, цэвэрлэгээний бодис, сав, баглаа, боодлын материал, сүлжмэл, Исламын хөрөнгө ,
Дунд	Сүүн бүтээгдэхүүн, загасан бүтээгдэхүүн, өндгөн бүтээдэхүүн, зөгийн аж ахуй, амтлагчууд, цэцэрлэгжүүлэлтийн аж ахуйтай холбоотой бүтээгдэхүүн, хадгалсан ногоо болон жимс, лаазалсан бүтээгдэхүүн, гоймон, элсэн чихэр, мал, амьтаны тэжээл, загасны тэжээл, усны хангамж, бүтээгдэхүүн, үйл явц, тоног төхөөрөмж боловсруулалт, мал эмнэлэгийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, автомат ТҮЦ машин, арьс ширэн бүтээгдэхүүн,
Бага	Загас, өндөг үйлдвэрлэл, сүү үйлдвэрлэл, загаслал, ан агнуур, урхидан барих агнуур, жимс, ногоо, үр тариа, шинэ жимс, шинэ шүүс, ундны ус, гурил, давс, жижиглэн худалдааны дэлгүүр, дэлгүүр, бөөний худалдаагчид, тээвэрлэлт болон хадгалалт;

С хавсралт
(норматив)

**Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах
чадамжийн шалгуур үзүүлэлтүүд**

C.1 Ерөнхий зүйл

Хүснэгт C.1-д Халал баталгаажуулалтын байгууллагын тодорхой баталгаажуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай чадамжийн шалгуур (мэдлэг болон ур чадвар)-ыг тусгасан. "Х" нь Халал баталгаажуулалтын байгууллагын шалгуур болон мэдлэг, ур чадварын хэмжээг илтгэнэ. Хүснэгт В.1-д тусгасан чадамжийн шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтийн дараах эхэд илүү дэлгэрүүлж тайлбарласан байх бөгөөд холбогдох дугаарыг хаалтанд дурьдсан болно.

**Хүснэгт C.1 - Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаанд
шаардлагатай чадамжийн шалгуур үзүүлэлтүүд**

Баталгаажуулалтын арга хэмжээ				
Чадавхийн шалгуур (мэдлэг, ур чадвар)	Өргөдөл, Гэрээг хянах, аудитын хугацаа болон багийн чадамжийн тогтоох, аудитын багийн гишигийн бүрэлдэхүүн	Аудитын бүртгэл, шийдвэр гаргалт	Исламын шашны эксперт	Аудит хийх, аудитын баг (Исламын шашны эксперт хамаарахгүй)-ийг удирдах
Үйлчлүүлэгч байгууллагын бизнестэй холбоотой Халал шаардлагын талаарх ерөнхий мэдлэг	X (B.4.1-ийг үзнэ үү)	X (B.3.1-ийг үзнэ үү)	X (B.5.1-ийг үзнэ үү)	X (B.2.1-ийг үзнэ үү)
Үйлчлүүлэгч байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ Халал байхад тавигдах Исламын шаардлагын талаарх мэдлэг			X (B.5.2-ыг үзнэ үү)	
Аудитын зарчим, туршлага, техникийн мэдлэг		X (B.3.2-ийг үзнэ үү)		X (B.2.2-ыг үзнэ үү)
OIC/SMIIC-ийн Халал стандарт/норматив лавлагааны талаарх мэдлэг	X (B.4.2-ыг үзнэ үү)	X (B.3.3-ыг үзнэ үү)		X (B.2.3-ыг үзнэ үү)
Халал баталгаажуулалтын байгууллагын	X (B.4.3-ыг үзнэ үү)			

Үйл явцын талаарх мэдлэг		X (B.3.4-ийг үзнэ үү)	X (B.5.3-ыг үзнэ үү)	X (B.2.4-ийг үзнэ үү)
Үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйл явц, байгууллагын талаарх мэдлэг	X (B.4.4-ийг үзнэ үү)			X (B.2.5-ыг үзнэ үү)
Харилцах ур чадвар, түүний дотор хэлний, ярилцлага хийх, танилцуулга хийх Г.М			X (B.5.4-ийг үзнэ үү)	X (B.2.6-г үзнэ үү)
Аудитын илрүүлэлт болон тайлан (бичгийн болон ярианы)-д зориулж тэмдэглэл хөтлөх ур чадвар			X (B.5.5-ыг үзнэ үү)	X (B.2.7-г үзнэ үү)
Аудит хийх гүйцэтгэх чадвар				X (B.2.8-ыг үзнэ үү)

C.2 Халал баталгаажуулалтын аудит хийх багийн гишүүдийн чадамжийн шаардлага

C.2.1 Үйлчлүүлэгч байгууллагын бизнестэй холбоотой Халал ерөнхий шаардлагын талаарх мэдлэг

Аудитын баг нь үйлчлүүлэгчийн бизнеставигдах нийтлэг Халал ерөнхий шаардлага, нэр томъёо, дадал, болон зах зээл, эцсийн хэрэглэгчийн хүлээлтийн талаар мэдлэгтэй байна.

ТАЙЛБАР - Бизнесийн салбарын эдийн засгийн үйл ажиллагаа (жишээ нь хүнс, гоо сайханы бүтээгдэхүүн, химийн бодис, аялал жуулчлал, санхүүгийн үйлчилгээ гэх мэт) гэж ойлгоно.

C.2.2 Аудитын зарчим, дадал, арга барилын мэдлэг

Аудитын багийн гишүүд нь аудитыг тууштай, дэс дараалалтай байдлаар гүйцэтгэх явдлыг хангахын тулд бодит нөхцөл байдалд зарчим, дадал, арга барилыг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвартай байна. Эдгээр мэдлэг, туршлагад аудитын явц дахь бүх шат хамрагдана. Үүнд төлөвлөлт, бэлтгэл, гүйцэтгэх, тайлагнах, асуудлыг эргэн мэдэгдэх, өмнөх үл тохирлыг запруулсан эсэхийг шалгах зэрэг хамаарна.

C.2.3 OIC/SMIIC-ийн Халал стандарт, норматив баримт бичгийн талаарх мэдлэг

Аудитын багийн гишүүд нь тусгайлсан баримт бичгүүд шаардлагад нийцэн, хэрэгжиж байгаа эсэхийг тогтоохын тулд OIC/SMIIC-ийн Халал стандарт, норматив баримт бичгийн шалгуурын талаар ойлголттой байх шаардлагатай.

C.2.4 Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аудитын багийн гишүүд нь Халал баталгаажуулалтын байгууллагын журамд нийцсэн аudit гүйцэтгэхийн тулд Халал баталгаажуулалтын байгууллагын үйл явцын талаар хангалттай хэмжээний мэдээлэлтэй байх шаардлагатай.

C.2.5 Үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, байгууллагын талаарх мэдлэг

Аудитын багийн гишүүд нь үйлчлүүлэгчийн ажиллагааны талаар мөн үйлчлүүлэгчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа шаардлагад нийцэж байгаа эсэхийг сайтар мэдэхийн тулд үйлчлүүлэгчийн үйл явц, бүтээгдэхүүний талаар хангалттай хэмжээний мэдлэгтэй байна.

C.2.6 Харилцааны ур чадварууд, үүнд хэл, ярилцлага хийх, танилцуулга хийх

Аудитын баг дипломат арга барилаар харилцах, ойлголцох чадвартай байна.

Аудитын баг нь ажиглалт, ярилцлага хийх замаар мэдээлэл авах, аудитад тохирох асуулт тавих, асуултад өгч буй хариултыг сонсох чадвартай байна.

Аудитын баг нь аудитын явцад цуглуулсан бодит байдлын нотлогоонд сууринсан, ойлгомжтой, хүлээн зөвшөөрөхүйц дүгнэлт, илрүүлэлтийг танилцуулах чадвартай байна. Багийн ахлагч нь үнэлгээний багийг төлөөлөх, аудитын хаалтын уулзалт, зөвлөгөөнөөр илрүүлэлт, дүгнэлт, ажиглалтыг танилцуулах чадварыг эзэмшсэн байна.

C.2.7 Аудитын илрүүлэлт, тайландаа зориулж тэмдэглэл хөтлөх (бичгийн болон ярианы) ур чадвар

Аудитын баг нь мэдээллийг эх үүсвэртэй нь дэс дараатайгаар тэмдэглэх, аль мэдээлэл нь аудитын даалгаварт хэрэгцээтэйг тодорхойлж, илрүүлэлтийг тайлбарлах чадвартай байна.

C.2.8 Аудит хийх гүйцэтгэх чадвар

Аудитын баг нь аудитын төлөвлөгөөний хүрээнд ажиллах чадвартай байна. Багийн ахлагч нь багийнхантайгаа мэдээлэл хуваалцах, зөвлөмж өгөх зорилгоор зөвлөгөөн зохион байгуулах мөн аудиттай холбоотой шийдвэр гаргах чадварыг эзэмшсэн байна.

C.3 Аудитын тайланг хянах, баталгаажуулалтай холбоотой шийдвэр гаргах, ажилтнуудад тавих чадамжтай холбоотой шаардлага

Ажилтнуудын чиг үүргийг нэг ба түүнээс дээш хүн гүйцэтгэх боломжтой байх.

C.3.1 Үйлчлүүлэгч байгууллагын бизнестэй холбоотой Халал ерөнхий шаардлагын мэдлэг

Аудитын тайлан хянаж, баталгаажуулалттай холбоотой шийдвэр гаргадаг ажилтнууд нь аудитын тайлан, үйлчлүүлэгчийн бизнест нийтлэг Халал ерөнхий шаардлага, нэр томъёо, дадал, үйл явц болон зах зээл, эцсийн хэрэглэгчийн хүлээлтийн талаар мэдлэгтэй байна.

C.3.2 Аудит/үнэлгээний зарчим, дадал, арга барилын талаарх мэдлэг

Аудитын тайланг хянах, баталгаажуулалттай холбоотой шийдвэр гаргадаг ажилтнууд нь шийдвэр гаргалтанд шаардлагатай бүртгэлийг гаргах мөн аудитын тайланг тайлбарлах мэдлэгийг эзэмшсэн байна.

C.3.3 OIC/SMIIC-ийн Халал стандарт/норматив баримт бичгийн талаарх мэдлэг

Аудитын тайланг хянах, баталгаажуулалттай холбоотой шийдвэр гаргадаг ажилтнууд нь шийдвэр гаргахаар цуглуулсан мэдээлэл, бүртгэл нь хангалттай эсэх, тайланда хангалттай хэмжээний мэдээлэл агуулсан, аудитаар OIC/SMIIC-ийн Халал стандарт, норматив баримт бичгийн хэрэгжилтийн талаар аудитын дүгнэлтэд тусгасан байна.

C.3.4 Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Аудитын тайланг хянах, баталгаажуулалттай холбоотой шийдвэр гаргадаг ажилтнууд нь шийдвэр гаргахад зориулж гаргаж өгсөн мэдээлэл, Халал баталгаажуулалтын байгууллагын журамд нийцсэн эсэхийг тодорхойлохын тулд Халал баталгаажуулалтын байгууллагын үйл явцын талаар хангалттай хэмжээний мэдлэгтэй байх шаардлагатай.

C.4 Өргөдөл хянах ажлыг гүйцэтгэдэг ажилтнуудад тавих чадамжийн шаардлага, аудит багт шаардлагатай чадамжийг тодорхойлох, аудитын багийг сонгох, аудит хийх хугацааг тодорхойлох

Эдгээр ажилтнуудын чиг үүргийг нэг ба түүнээс дээш хүн гүйцэтгэх боломжтой байх.

C.4.1 Үйлчлүүлэгч байгууллагын бизнестэй холбоотой Халал ерөнхий шаардлагын талаарх мэдлэг

Өргөдөл хянах ажлыг гүйцэтгэдэг ажилтнууд нь аудитын цагийг үр дүнтэйгээр тодорхойлох мөн аудитын багт чадамж бүхий гишүүдийг томилохын тулд үйлчлүүлэгчийн бизнест нийтлэг Халал ерөнхий шаардлага, нэр томъёо, дадал, үйл явц болон зах зээл, эцсийн хэрэглэгчийн хүлээлтийн талаар мэдлэгтэй байна.

C.4.2 OIC/SMIIC-ийн Халал стандарт, норматив баримт бичгийн талаарх мэдлэг

Өргөдөл хянах ажлыг гүйцэтгэдэг ажилтнууд нь холбогдох стандарт болон норматив баримт бичгийн талаар тодорхой мэдлэгтэй байна.

C.4.3 Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Өргөдөл хянах ажлыг гүйцэтгэдэг ажилтнууд нь аудитын хугацааг үр дүнтэйгээр тодорхойлох, аудитын багт чадамж бүхий гишүүдийг томилохын тулд Халал баталгаажуулалтын байгууллагын мөрдөж буй журмын талаар мэдлэгтэй байна.

C.4.4 Үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, байгууллагын талаарх мэдлэг

Өргөдөл хянах ажлыг гүйцэтгэдэг ажилтнууд нь аудитын хугацааг үр дүнтэйгээр тодорхойлох, аудитын багт ур чадвртай гишүүдийг томилохын тулд үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний талаар мэдлэгтэй байна.

C.5 Исламын шашны экспертийн чадамжийн шаардлага

C.5.1 Үйлчлүүлэгч байгууллагын бизнестэй холбоотой Халал ерөнхий шаардлагын талаарх мэдлэг

Исламын шашны эксперт нь үйлчлүүлэгчийн бизнест нийтлэг Халал ерөнхий шаардлага, нэр томъёо, дадал, үйл ажиллагаа болон зах зээл, эцсийн хэрэглэгчийн хүлээлтийн талаар мэдлэгтэй байна.

C.5.2 Үйлчлүүлэгч байгууллагын бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлчилгээ халал байх талаарх Исламын Шаардлагын мэдлэг

Исламын шашны эксперт нь тохирлыг үнэлэхийн тулд баталгаажуулалт хийлгэх гэж буй бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой Исламын Дүрмийн талаар цогц мэдлэгтэй байна. Энэхүү чадамжийг Халал эрх бүхий байгууллага (ИХАБ/ИОСХЗХ 2, Хэсэг 3.2-ыг үзнэ үү) баталж, зөвшөөрсөн байх шаардлагатай.

C.5.3 Халал баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Исламын шашны эксперт нь Халал баталгаажуулалтын байгууллагын журамд нийцсэн аудитыг гүйцэтгэхийн тулд Халал баталгаажуулалтын байгууллагын үйл явцын талаар хангалттай хэмжээний мэдлэгтэй байх шаардлагатай.

C.5.4 Харилцааны ур чадварууд, үүнд хэл, ярилцлага хийх, танилцуулга хийх чадвар

Исламын шашны эксперт нь аудитын баг дипломат арга барилаар харилцах, ойлголцох чадвартай байна. Тэрбээр ажиглалт, ярилцлага хийх замаар мэдээлэл авах, аудитад тохирох асуулт тавих, асуултад өгч буй хариултыг сонсох чадвартай байна. Исламын шашны эксперт нь аудитын явцад цуглуулсан объектив нотлоогоонд сууринсан, ойлгомжтой, хүлээн зөвшөөрөхүйц дүгнэлтийг танилцуулах чадвартай байна.

C.5.5 Аудитын илрүүлэлт, тайланд зориулж тэмдэглэл хөтлөх (бичгэн болон ярианы) ур чадвар

Исламын шашны эксперт нь мэдээллийг эх үүсвэртэй нь эмх цэгцтэй тэмдэглэх, аль мэдээлэл нь аудитын даалгаварт хэрэгцээтэйг тодорхойлж, илрүүлэлтийг тайлбарлах чадвартай байна.

Ном зүй

1. ISO 9000, Чанарын менежментийн тогтолцоо - Үндсэн асуудал ба тайлбар толь,
2. ISO 9001, Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлагууд,
3. ISO 10002, Чанарын менежмент - Харилцагчийн сэтгэл ханамж - Байгууллагад гомдол шийдвэрлэх удирдамж,
4. ISO/IEC 17024, Тохирлын үнэлгээ - Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага,
5. ISO/IEC TR 17026, Тохирлын үнэлгээ - Биет бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн загвар,
6. ISO/IEC 17030, Тохирлын үнэлгээ - Гуравдагч талын тохирлын тэмдэгт тавигдах ерөнхий шаардлага,
7. ISO/IEC 17067 - Тохирлын үнэлгээ - Бүтээгдэхүүн баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн загвар,
8. Олон Улсын зөвлөмж - Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим. САС/RCP 1-1969, дөрөвдүгээр хэвлэл 2003 он,
9. Хүнсний эрүүл ахуйн дүрмийн үндсэн эх, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Ром хот, 2001 он.